"ТӨВ АЗИЙН ГЕОПОЛИТИК, ГЕОЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН БА МОНГОЛ УЛС" СЭДЭВТ ДУГУЙ ШИРЭЭНИЙ ЯРИЛЦЛАГА

ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгээс (ОУСХ) эрхлэн гаргадаг улирал тутмын "Олон улс судлал" (ОУС) сэтгүүлийн редакциас 2004 оны 5-р сарын 12-нд ***"Төв Азийн геополитик, геоэдийн засгийн орчин ба Монгол Улс"*** *сэдэвт дугуй ширээний ярилцлага зохион байгуулав. Суулийн жилуудэд олон улсын терроризмын эсрэг тэмцэл, эрчим хүчний альтернатив эх сурвалж болох ирээдүй төлөвтэй уялдан Төв Азийн бус нутаг дэлхий нийтийн анхаарлын төвд орох болсон бөгөөд уг бус нутагт өрнөж буй нарийн төвөгтэй, зөрчилтэй үйл явцыг аль болох тал бүрээс нь бодитой харуулах, үл ойлголцол, гаргалгаа хийх явдал энэхүү ярилцлагыг зохион байгуулах чухал үндэслэл болж байна. Мөн түүнчлэн Монгол Улс Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагад элсэх эсэх асуудал манай улсын дотоодод төдийгүй хилийн чанадад ч ихээхэн анхаарал сонирхлыг татаж байгаа билээ. Дугуй ширээний ярилцлагад Гадаад Хэргийн яам, Стратегийн судалгааны хүрээлэн, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль, Боловсролын их сургууль, Батлан хамгаалахын их сургууль, МУИС-ийн геологи, газар зүйн факультетийн нийгмийн газар зүйн тэнхим зэрэг төр засаг, эрдэм шинжилгээ, боловсролын байгууллагуудын энэ чиглэлээр дагнан ажиллаж буй эрдэмтэн, профессор, судлаач, мэргэжилтнүүд уригдан оролцлоо. Энэ удаагийн дугуй ширээний ярилцлаганд манай улсын гадаад бодлогын чиг шугамыг боловсруулах, төлөвлөх үйл явцад оролцдог албаны хүмүүс, дипломатууд, нэртэй эрдэмтэн судлаачид оролцож байгаа боловч энд уг хэлсэн хүмүүс маань төр, засгийн болон судалгааны байгууллагын албан ёсны байр суурийг илэрхийлээгүй бөгөөд тухайн хүний хувийн үзэл бодол, байр суурь хэмээн хүлээн авч, мэргэн ойлголцоо ухаандаа тунгаан болгоохыг өргөн олон уншигчдаасаа хүсч байна.*

Сэтгүүлийн редакц

Д.Шүрхүү (ОУСХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, сэтгүүлийн орлогч эрхлэгч Ph.D): Манай урилгыг хүлээн авч өнөөдрийн дугуй ширээний ярилцлагад хүрэлцэн ирсэн та бүхэнд талархал илэрхийлье. Хэлэлцэх асуудлыг тодруулах, түүний үр өгөөжийг нэмэгдүүлэх, ярилцлаганд оролцогчид хэлэлцэх асуудлаар зохих түвшинд бэлтгэж ирэх нөхцөл бололцоог хангах үүднээс сэтгүүлийн редакциас Төв Азийн бүсийн хамгийн чухал, тулгамдсан асуудлууд хэмээн дор дурдсан сэдвүүдийг хэлэлцүүлгийн гол чиглэл болгон дэвшүүлж, та бүхэнд тараасан урилгандаа ч энэ тухай дурдсан билээ. Үүнд:

1. Өнөөгийн Төв Ази гэж юу вэ? Төв Ази хэмээх түүх, газар зүйн болон геополитикийн сонгодог ойлголтууд ба өнөөгийн бодит байдал, түүнд Монгол Улсын холбоо хамаарал;

2. Төв Азийн улс орнуудын улс төр, эдийн засгийн хөгжил, шашин-үндэстний харилцааны ерөнхий байдал, цаашдын төлөв;

3. Төв Ази дахь их гүрнүүдийн ашиг сонирхол, өрсөлдөөн зөрчил, тэдний бодлого, үйл ажиллагаа;

4. Төв Азид бүс нутгийн улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагааны систем бүрэлдэн төлөвших боломж, арга зам, хэтийн төлөв, түүнд нөлөөлөх эрэг, сөрөг хүчин зүйлүүд. Энэ үйл явцад Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын гүйцэтгэх үүрэг, нөлөө;

5. Монгол Улсын гадаад бодлогод Төв Азийн бүсийн эзлэх байр суурь, цаашид үзүүлэх нөлөө, хэтийн төлөв эдгээр болно.

Та бүхэн манай редакцийн зүгээс дэвшүүлэн тавьсан дээрх асуудлуудаар болон өөрсдийн сонирхон судалж буй Төв Азийн бүсийн бусад асуудлаар ч чөлөөтэй, илэн далангүй эрдмийн халуун яриа хэлэлцүүлэг өрнүүлнэ гэдэгт найдаж байна.

К.Дэмбэрэл (ОУСХ-ийн ЭШАА, Ph.D): Анх 1800 онд Германы эрдэмтэн А.Гумбольдт өөрийн бүтээлдээ "Төв Ази" гэсэн нэр томъёо хэрэглэсэн байдаг. 1989 онд хэвлэгдсэн Оросын нэвтэрхий тольд "Төв Ази – гэдэг нь Хятад, Монголын нийт 6 сая хав.дөр.км нутгийг хамарсан байгалийн бүсийг хэлнэ" гэж бичжээ. Оросын эрдэмтэн В.М.Синицын 1959 онд "Төв Азийн нутаг дэвсгэр нь 4360 мян.хав.дөр.км буюу нийт Ази тивийн 1/9 хэсэг" гэж тэмдэглэсэн. Мөн зарим эрдэмтдийн томъёолсноор "Төв Азийн нийт нутаг дэвсгэрийн 3/4 нь БНХАУ-ын нутагт, 1/4 орчим нь Монголын хэсэгт оршдог" гэжээ. Мөн Дорнод Памир, Өмнөд Тувагийн зарим хэсгийг оруулсан байдаг. Төв Азийн тогтсон хил одоогоор байхгүй байгаа.

"Төв Ази" хэмээх нэр томъёо нь гадныхны, тухайлбал европыхноос "бидэнд" өгсөн нэр. Анхандаа Азийн тивийн гүнд орших, хүрч очиход төвөгтэй, түгжигдмэл, гадаад далайгаас хэт алслагдсан бүсийг "Дотоод Ази" хэмээн нэрлэсэн. Энэхүү "тодорхой бус" тодорхойлолт нь бүс нутгийн судлагдаагүй, европыхон хүрч очоогүй хэсэгт л оноогдсон. Дотоод Азийг европыхноос илүү судалсан нь оросууд. Дотоод Ази нь судалгааны объект болсон үеэс энэ нэр томъёо зөвхөн газар зүйн нэр байхаа больж түүх-соёлын утга санааг агуулах болжээ. XIX зууны II хагас гэхэд хойд талаас нь Оросын эзэнт улс, Их Британий эзэнт улс өмнө талаас нь шахсаар Дотоод Азийн орон зай илүү багасаж тэр утгаараа томъёолол нь ч өөрчлөгдөх болсон.

Төв Азийн нийгэм-улс төрийн орон зайн урт удаан түүхэн хөгжлийн явцад янз бүрийн хүчин, түүний нөлөөгөөр үүсчээ. Түүхэнд нүүдэлчдийн шилжилт хөдөлгөөн нь энэ бүс нутгийн гео-соёлд томоохон түлхэц өгсөн билээ. Эртний түрэг, монгол угсааны нүүдэлчдийн аж төрж байсан үеэс энэ орон зай өргөжин тэлж, өнөөдрийн Төв Азийн нутаг дэвсгэр нь зүүн талдаа Монгол, баруун талдаа Хар далайн зүүн эрэг, хойд талдаа Сибирийн ойт хээрийн нутаг, өмнө талдаа Ираны өндөрлөгүүд хүрч байлаа. Ийм өргөн уудам нутаг бүхий орон зай түүхийн явцад зөвхөн хэмжээний хувьд хувьсан өөрчлөгдсөн төдийгүй нэр томъёоны хувьд ч янз бүрээр нэрлэгдэж ирсэн. Энэ нь нэгдүгээрт, нүүдэлчдийн орон зай байсан нь тал талаасаа "хялбар тонуулах" нөхцөл болсон.

Дараа нь нэг хэсэг Төв Ази гэдэг нь Каспийн тэнгисээс Хянганы нуруу хүртэлх өргөн уудам нутаг дэвсгэр дээрх түрэг, монгол ард түмнүүдийн өлгий хэмээн тодорхойлох болсон. Өөрөөр хэлбэл баруун талаасаа танагдчихсан гэсэн үг. Европын газар зүйчид түрэгийн угсааны нүүдэлчдийн голлон аж төрдөг нутгийг "Түркестан" хэмээх нэр томъёог ашиглан тэмдэглэх болсон. Оросын эзэнт улсын харъяаны нутаг болох "Дундад Азийг" Баруун Түркестан, Хятадын Шинжааны хэсгийг Зүүн Түркестан хэмээн нэрлэх болсон.

Каспийн сав газар дахь Төв Азийн улсуудыг хятадууд /эртний болон дундад зууны үеийн Хятадууд түүнийг "Баруун хязгаар" (Сиюй)/ "Их Төв Азийн" хэсэг хэмээн нэрлэдэг байсан. Бүр 1904 онд Их Британий геополитикч Х.Маккиндер Евразийн төвийг газар зүйн хувьд Волга /Ижил/ мөрнөөс Лена мөрөн хүртэл баруунаас зүүн зүгт, хойноос урагш Хойд Мөсөн далайгаас Персийн булан бараг хүргэж "Бүсийн тэнхлэг" хэмээн тодорхойлсон нь хожим буюу 1919 онд "Хартлэнд" нэрийг олсон. Энэ бүс нутаг нь Гадаад далайд гарах гарцын хувьд хэцүү ч орчин үеийн дэлхийн гол гол бүсүүдэд орох гарцыг хянаж байлаа.

Х.Маккиндерын дүгнэлтэд Оросын сонгодог геополитикч, генерал А.Е.Снесарев онолын нөлөө үзүүлсэн. Снесарев "Дундад Ази" хэмээх бүсэд "Оросын Түркестан, Шинжаан буюу Хятадын Түркестан, Энэтхэг, Афганистан, Иран болон Төвд"-ийг оруулж томъёолсон. Тэрээр энэ "Том Дундад Азийг" дэлхийн бодлогын "түлхүүр" хэмээн нэрлэсэн.

Тухайн үедээ НҮБ-аас геополитикийн түүхэн уламжлалаас нь хамааран Азийг баруунаас нь зүүн тийш Баруун, Төв, Зүүн хэмээн газар зүйн хувьд хуваасан байдаг. Геополитик гэдэг нь газар зүйг өргөн дэлгэсэн ойлголт бус бүр тодруулбал "газар зүйн улс төрийн бодлого" ч бус харин газар зүйн хүчин зүйлийн нөлөөтэйгээр түүхэн үйл явдлыг улс төрийн хувьд удирдах үйл явцыг хэлнэ хэмээн зарим онолчид тэмдэглэсэн байдаг.

Оросын сонгодог геополитикууд болох фельдмаршал Д.А.Милютин, генерал Г.А.Леер, А.Е.Снесарев нар ч тийм бодолтой байсан. Бүс нутаг нь түүхийн тодорхой үеүдэд түүнд хамаарахгүй янз бүрийн эзэнт улсуудын бүрэлдэхүүнд багтаж байлаа. XIX зуунд Оросын эзэнт улс Төв Азийг өөртөө нэгтгэн нэгэн бүхэл цогцос болгоод түүнийг "Дундад Ази ба Казахстан" хэмээх болсон ба Төв Азид хамаарах ихэнхи улсууд түүний мэдэлд орж эзэнт гүрний хэмжээнд 70 шахам жил оршин тогтнож байлаа. Тийнхүү Төв Азийн бүс нь геополитикийн ойлголтын хувьд хөгжиж ирсэн түүхтэй хэмээн зарим судлаачид үздэг. Хэдийгээр гадаад далай, эрэг хавийн улсуудаас алслагдмал хэдий ч орчин үеийн геополитик нь Төв Азийг глобал асуудлаас тийм ч алслагдмал байлгахгүй байгаа. Төв Ази нь Евразийн 4 бүсийн геополитикийн хүчин зүйл болоод байна. Үүнд: Дундад, дорнод Ази, Номхон далай, Өмнөд Ази, Европ. Энэ нь тухайн чиглэлийн судалгааг гүнгийрүүлэхийг зүй ёсоор шаардаж байгаа.

Хоёр системийн оршин тогтнож буй үед Төв Ази хэмээх ойлголтыг гаргаж тавих нь боломжгүй байлаа. Учир нь энэ бүс нутаг бараг бүхэлдээ Зөвлөлтийн нөлөөнд байсан. Харин системийн задрал нь энэ бүс нутгийг бие даан дэлхийн бодлогын субъектын хэмжээнд гарч ирэх боломжийг нээлээ.

Өнөөдөр Төв Ази нь зарим судлаачдын дүгнэлтээр "Евразийн Балкан" хэмээх ойлголтыг хүртээд байгаа. Өөрөөр хэлбэл янз бүрийн мөргөлдөөний гол цэг байж болох үндэстэй гэсэн үг.

ЗХУ задарснаар дэлхийн улс төр, эдийн засгийн бүтцэд Төв Ази нь өөрийн гэсэн байр суурьтай болж байгалийн баялаг, газар зүйн байрлал, олон улсын харилцааны өвөрмөц субъектын хувьд их гүрнүүдийн анхаарлын төвд шинээр орж ирсэн. Дундад Азийн судлаачдын үзэж буйгаар өнөөгийн Төв Азийн баруун хил нь Каспийн тэнгис, зүүн талдаа Тянь-Шань, Алтайн уулын бүс, өмнө талдаа

Хорасаны уулс, мөн Пянж, Амударья, Атрек мөрнөөр хязгаарлаж байгаа. Өөрөөр хэлбэл Төв Ази нь /одоо 4 сая хав.дөр.км/ анх томъёологдож байсан хэмжээнээсээ 2 илүү дахин багассан ажээ. Бүр 1993 оны 1-р сарын Алма-Атагийн уулзалтаар ТУХН-ийн орнуудын тэргүүн нар "Төв Ази" гэсэн бүсэд хуучин Зөвлөлтийн Дундад Азийн 5 БНУ-ыг л зөвхөн хамарна гэсэн төр-эрхзүйн үндэслэлийг баталгаажуулсан юм.

Газарзүйн байрлал нь гадаад бодлогоо тодорхойлдог гэсэн геополитикийн аксиом байдаг шүү дээ. Газарзүйн байрлал гэдэг бол хувь заяа.

Эцэст нь хэлэхэд, Төв Азийн бүс нутгийн талаархи судалгаануудыг тоймлон үзвэл дараахи дүр зураг гарч байна. Үүнд:

- Төв Азийг дэлхий дахинаа зөвхөн аюулгүй байдлын бүсийн хүрээн судалж, энэ талыг хөндсөн, шинжилсэн бүтээлүүд орос, америк, хятад, европын судлаачдын гол ажил нь болж байна. Хэрвээ хувиар илэрхийлбэл 60% байх.

- Бүс нутгийн эрчим хүчний нөөц, олборлолт, тээвэрлэлт гэсэн асуудал судалгааны ажлын 30% нь,

- Харин бүс нутгийн соёл, эдийн засгийн хөгжил, улс төрийн харилцааны асуудлыг хөндсөн судалгаа 5-10% байх жишээтэй. Гэхдээ сүүлийн чиглэлийн судалгааг ихэвчлэн Төв Азийн орнуудын судлаачид л явуулж байгаа.

М. Баянтөр (МУИС-ийн Геологи, газар зүйн факультетийн нийгмийн газар зүйн тэнхмийн багш, профессор): Сүүлийн үед Азийн бүс нутгийн хуваарилалтын бүдүүвчинд янз бүрийн ойлголтууд бий болж байна. Тэр нь миний бодлоор дараах хүчин зүйлүүдээс үүсэлтэй болов уу.

Улс орнуудыг хуваарилаж райончлахдаа салбарын чиг хандлагыг илүүтэй хэрэглэх болсон. Жишээ нь: Бүх Дэлхийн Банкнаас улс орнуудыг хүн амд ногдох орлогоор нь бүлэглэж аж үйлдвэр өндөр хөгжсөн орнууд, шинээр хөгжиж буй орнууд гэж хуваах болжээ. Энд газар зүйн хүчин зүйлийг харгалзаж үзээгүй байна. Жишээ нь: Дэлхийн хөгжлийн индикатор 2001. /Дэлхийн банк. Вашингтон 2001/ номонд хуучин социалист гэгдэж байсан Дорнод Европын орнууд Туркийг Европ, Төв-Ази гэсэн бүс нутагт оруулсан байна. Энэ мэт жишээг олныг дурдаж болох юм.

Ази бол дэлхийн хуурай газрын 30%-ийг эзэлдэг өргөн уудам нутаг. Энд дэлхийн хүн амын 3/1 төвлөрөн суурьшдаг бөгөөд нийтдээ

Тайванийг оролцуулалгүйгээр 48 улс байна. Сүүлийн 10-20 жилд дэлхий дэх геополитикийн төлөв байдал өөрчлөгдөж тусгаар бие даасан улсууд, бүс нутгийн шинж чанартай холбоо, нэгдлүүд бий болсонтой уялдаад Ази тивийн улсуудыг бүсчлэн хуваах асуудал нэлээд төвөгтэй болсон байна. Азийн дорнод хэсэгт Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагаа гэдэг эдийн засгийн бүлэглэл бий болж байна. Ази-Номхон далайн бүс нутаг ба Номхон далайн Ази гэдэг ойлголтууд бий болсон байна. НҮБ, Дэлхийн Банк зэрэг байгууллагын статистикт Номхон далайн Ази гэдэг нэр томъёог хэрэглэх болсон байна. Түүнд Зүүн ба Зүүн өмнөд, Өмнөд Азийн газар зүйн уламжлалт бүсүүдийг оруулдаг болжээ. Бас ОХУ-ын Алс Дорнодыг /Зүүн хойд Ази/ зарим нэг тайлбартайгаар оруулах болсон байна. Австрали-Ази гэдэг бүс нутагт Япон, Өмнөд Солонгос, Хятад, Тайвань арал, АСЕАН-ны орнууд, Австрали, Шинэ Зеландыг оруулан нэрлэх болсон байна. Азийн баруун хэсэгт НАТО-гийн болон ялангуяа Европын Холбоо хил хязгаараа тэлж байгаа нь энэ газар зүйн нэр томъёог өөрчлөхөд хүргэж байна. Дөнгөж сая Каприйн Грекийн хэсэг Европын Холбооны гишүүн боллоо. Энэ оны 12-р сард Туркийг Европын Холбоонд элсүүлэх талаар гэрээ хэлцэл хийгдэхээр завдаж байна. Ингэхлээр Европын Холбоо Европ-Азийн эдийн засгийн холбоо болж хуваагдах нь ээ.

ЗХУ-ын бутралаас улбаалж Төв-Азид өөрсдийгөө /Төв-Азийн улсууд/ гэж нэрлэсэн бүс нутаг бий боллоо. Ингэхлээр энэ улсууд бие даасан бүс нутгууд эсвэл шилжилтийн үедээ байгаа юу гэдэг асуудал гарч байна. Ер нь Төв-Ази гэдэг нэрийн дор урьд өмнө Азийн төв хэсгийн өргөн уудам уулархаг нутгийг харуулдаг физик газар зүйн ойлголт байсан. Түүний хил хязгаарыг тогтоох талаар Оросын эрдэмтэн Н.Синицен өөрийн ном зохиолдоо дэлгэрэнгүй өгүүлсэн байдаг. Монголчууд бид ч гэсэн Азийн төвд оршдог хэмээн их л өндөр дуугаар ярих дуртай боловч НҮБ-ын ангиллаар Монголыг Зүүн Азийн бүсэд оруулсан байдаг билээ. Ер нь бүс нутаг буюу регион гэдэг бол маш өргөн ойлголт. Энэ үгийн дор газар зүйн бүрхэвчийн хувьд гарал үүсэл нэгтэй харилцан нөлөөлөл бүхий нутаг дэвсгэрийн бүхэл бүтэн хэсгийг хэлдэг юм. Тэрчлэн газар зүй, соёл, түүхэн нийтлэгээрээ хоорондоо харилцан холбоо бүхий хэсэг бүлэг улсууд, эсвэл эдийн засаг, санхүүгийн хувьд, эсвэл улс төр хүн амын ястан үндэстэн, шашин соёлын хувьд ойр дөхөм төрөл садан тийм социал-институтийн нэгдлийг хэлдэг. Ингэхлээр Төв-Ази гэдэг бүс нутгийг тодорхойлохын тулд:

1. Газар зүйн нэгдмэл байдлыг харгалзах хэрэгтэй
2. Нутаг дэвсгэр хүн амын томоохон хэсэг байх хэрэгтэй

3. Ижил төстэй талууд нь ялгаанаас давж байх ёстой

4. Соёл иргэншил, түүхийн хувьд ойр дөт бүр төрөл садан байдлыг харгалзан үзэх ёстой.

Ингээд үзвэл аливаа улс орнуудыг нэг бүс нутаг болгохын тулд олон хүчин зүйлүүдийг харгалзан авч үзэх шаардлагатай болж байна.

Одоогийн байдлаар Төв-Азийн бүс нутаг гэдэгт ЗХУ-ын нэр томъёогоор Казахстан болон Дундад Азийн улсууд тухайлбал Казахстан, Киргыз, Тажикстан, Узбекстан, Түркменстан улсуудыг оруулж байгаа юм.

Илтгэгч миний үзэж байгаагаар Төв-Ази гэдэг энэ ойлголт бүрэн бүрдэл болж чадаагүй завсрын бүсний тухай ойлголт юм. Зөвхөн хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улсууд гэдгээр нэрлэж байгаа юм. Газар зүйн хувьд авч үзвэл энд ОХУ-ын бүрэлдэхүүн хэсгүүд болох Буриад, Тува /Төв-Азийн гол цэг Тувагийн нутаг дэвсгэрт байж байгаа гэж үзээд хөшөө босгожээ/, Алтайн БНУ, Оросын зарим мужууд /Иркутск, Чита/, Монгол, Афганистан улсууд багтаж болох юм. Хэрэв улс төрийн хувьд нэгдмэл нэг бие даасан улсууд орох ёстой гэвэл Казахстан, Дундад Азийн 4 улс, Афганистан, Монгол Улс багтах бүрэн боломжтой. Хэдийгээр Казахстан, Монгол Улсын хилийн дундуур Оросын нарийн зурвас нутаг орж ирж байгаа боловч Монголын баруун хилээс Дорнод Казахстан хүртэл 40 гаруй км байдгийг санах хэрэгтэй. Илтгэгч миний бие "Улс төрийн газар зүй" /УБ, 2003/ номондоо энэ тухай товч санаагаа цухалзуулаад Төв ба Зүүн Азийн орнууд гэсэн томъёоллыг гаргаж тавьсан юм. Үүндээ Монгол, Хятад, Хойд, Өмнөд Солонгос, Япон, Казахстан, Киргыз, Тажикстан, Узбекстан, Афганистан улсуудыг оруулсан. Эдгээрээс дээр дурдсан Төв-Азийн бүс нутаг түүх, соёл иргэншил, хүн амын ястан үндэстний бүтэц, байгаль цаг уурын нөхцлөөр өөр хоорондоо ихээхэн төстэйг тэмдэглэвэл зохино. Тухайлбал Афганистан нь Тажикстан, Кыргызтэй газар зүйн хэд хэдэн шинжээр /эх газрын байдалд байрлалтай, өндөр уулархаг, далайд гарах гарцгүй/ ижил төстэй юм. Монголд ч гэсэн Төв-Азийн бусад улсуудын нэгэн адил далайд гарцгүй орон юм. Гэхдээ давтан өгүүлэхэд Төв-Азийн бүс нутаг бол одоогоор улс төр, эдийн засгийн олон хүчин зүйлүүдээс шалтгаалаад бүрэн бүрэлдэж чадаагүй шилжилтийн үедээ байгаа бүс нутгийн улсуудтай цаашид олон талаар холбоо хамааралтай байх нь дамжиггүй.

Н.Одхүү (Газар зүйн хүрээлэнгийн ЭША): Дундад зуунд европчуудад татар гэж нэрлэгдсэн Монголчуудын оршин суух буй газар орныг /Төв Азийг/ XIII зуунд Тартарии хэмээн нэрлэдэг байсан

байна. “Тартарии” гэдэг нь Азийн төв хэсэг гэсэн утгатай бөгөөд газар зүйн нэр томъёоноос XVIII-XIX зуунд хасагдсан юм.

“Төв Ази” гэдэг ойлголт нь Азийн энэ хэсэгт зориулсан Германы нэрт газар зүйч, байгаль судлаач эрдэмтэн А.Гумбольдтын сонгодог бүтээлийн ачаар XIX зууны 2-р хагаст шинжлэх ухааны бүтээлд орж ирсэн юм. А.Гумбольдт уртрагаар Тураны нам тал ба Их Хянганы нурууны хоорондх, өргөргөөр Алтайн нуруу Гималайн нурууны хоорондох өндөрлөг бэгэлцэг-уулархаг нутгийг Төв Ази гэж нэрлэсэн байна. А.Гумбольдтын гавьяа нь говь хүртэлх бүх Дотоод Ази багтаж байсан агуу уудам “Өндөр Тартарии”-н тухай ойлголт төсөөллийг өөрчилсөн явдал байв. Энэ нь Европт XIII зуунаас эхэлсэн уул, цөлийн орон зайгаар дүүрэн уудам өндөрлөг, цаст уулс бүхий Өндөр Татар, Тартар гэсэн нэр авч байсан ойлголтыг түрэн зайлуулсанд оршино.

Харин Э.М.Мурзаев Төв Азийг зөвхөн физик газар зүйн утгаар нь хязгаарлалгүй, Монгол Улсын хилийг эвдэлгүйгээр Өвөр Байгалийн ойт хээрийн үргэлжлэл болох Орхон, Хэрлэн, Сэлэнгийн дээд урсгалын сав газрыг Төв Азид багтаахыг санал болгож байв.

Монгол Улсын нутаг БНХАУ-ын Төв Азийн секторын хамтаар Төв Ази гэсэн физик газар зүйн сонгодог муж болох ба Оросын Өмнөд Сибирийн уулсын бүс нь энэ мужийн хойд зах болж байдаг. Энэ байгалийн муж нь Энэтхэгийн платформ (газрын гадаргын харьцангуй тогтвортой хэсэг) ба Сибирийн платформын хооронд шахагдан өргөгдсөн өндөрлөг нутаг ба зүүн өмнөөсөө Хятадын платформд тулсан байдаг юм.

Төв Ази газар зүйн орон зайн нийлмэл Схем 1



Судлаач миний хувьд ойлгож буй "Төв Ази" газар зүйн бүсэд Орос-Зөвлөлтийн эрдэмтдийн санал болгосон "Төв Ази" физик газар зүйн муж дээр хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Дундад Азийн таван БНУ, ОХУ-ын Өмнөд Сибирийн уулсын бүс багтаж байна. Харин энэ Төв Ази ойлголтод Каспийн сав бүхлээрээ хамаарахгүй бөгөөд Каспийн эрэг орчмын бүс бол Дорнод Европ, Төв Ази, Баруун өмнөд Ази гэсэн Евразийн 3 бүсийн зааг нутаг буюу Ойрхи Дорнодын хойд хэсэг болон ЗХУ задарсны дараа гарч ирж буй Ойрхи Дорнодын нэг дэд бүс юм. XX-XXI зууны заагт Баруунд хэрэглэх болсон "Төв Еврази" гэсэн ойлголтод Каспийн сав газар Төв Азийн таван БНУ-ын хамт орж хэрэглэгдэх болсон байна.

Оросын Төв Азийн секторт ОХУ-ын Буриад, Тува, Алтайн БНУ, Чита муж, Алтайн хязгаар, Кемеров муж, Эрхүү мужийн баруун өмнөд хагас, Красноярскийн хязгаарын өмнөд хэсэг багтдаг.

БНХАУ-ын Төв Азийн секторт Өвөр Монгол, Төвд, Шинжаан-Уйгурын ӨЗО, Хөх нуур муж, Ганьсу мужийн баруун хагас /Ганьсугийн коридор/ багтана.

Хүснэгт 1-д дурдсан Төв Ази нь баруун талаар Оросын буюу Дорнод Европын платформ, өмнө талаар Энэтхэгийн платформ, хойд талаар Сибирийн платформ, зүүн өмнөөс Хятадын платформоор хүрээлэгдсэн газрын гадаргын нэлээд хөдөлгөөнтэй хэсэг болох юм.

Монгол Улс нь Төв Азийн салшгүй хэсэг бөгөөд Төв Азийг Зүүн хойд Азитай холбогч сэжим болж байдаг. Төв Ази нь орон зайн бүтцийн хувьд байгаль, нийгэм, эдийн засгийн маш өвөрмөц нийлмэл болохыг /схем 1-ээс/ харж болно.

Хүснэгт 1

№	Төв Азийн секторууд	Талбай мян.км кв	Хуурай газарт эзлэх %	Ази тивд эзлэх %	Евразид эзлэх %	Төв Ази
1	Монгол Улс	1564.4	1 %	3 %	3 %	12 %
2	Дундад Азийн 5 улс	3994.4	2,7 %	8 %	7 %	31 %
3	БНХАУ-ын сектор	5200				42 %
4	ОХУ-ын сектор	1800				14 %
	Төв Ази	12615.8	9,6 %	28,8 %	23,7 %	100 %

Одоо Төв Азийн улс төр, эдийн засаг, соёл-угсаатны харилцааны орон зайн онцлогийн талаар товч дурдая. Германы эрдэмтэн

Кристаллерийн гаргасан "Төв байршлын онол" ёсоор бол Төв Ази нь зөвхөн Евразийн эх газрын газар зүйн орон зайн төв төдийгүй соёл иргэншил, эдийн засаг, шашины огтлолцох уулзвар зааг болж байдаг. Мөн Дорно дахин гэсэн эртний ойлголтын хамгийн хойд хэсэг нь нүүдэлчин монголчууд буюу одоогийн Монгол Улс болдог.

Төв Ази нь бүхэлдээ түүхийн бүх л үеийн турш Өрнө Дорно, Өмнө Умрыг холбогч "гүүр" буюу "тээврийн хонгил" болж ирсэн түүхтэй. XYII зуунаас хойш далайн тээвэр хуурай газрын тээврээс хямд болж давуутай хөгжиж ирсэн бөгөөд ШУ-Техник, технологи үсрэнгүй хөгжиж буй XXI зуунд эх газрын тээвэр дахин эрчимтэй хөгжих эхлэл тавигдаж байна. Төв Ази бол ирэх мянганы ирээдүйн шинэ "Суэцийн суваг" болох хэтийн ирээдүйтэй юм.

Каспийн сав газрыг тойрсон эрчим хүчний томоохон төслүүд нь хэтдээ тээврийн олон улсын төслүүд болон өргөжих хандлага ажиглагдаж байна. Каспийн савыг багтаасан Төв Ази буюу Төв Еврази нь Баруун Европ, Дорнод Ази гэсэн дэлхийн эдийн засгийн хоёр төвийг холбож байдаг нь Төв Азийн улс төр, геополитикийн харилцааны ач холбогдлыг тодорхойлж байдаг. Тээврийн газар зүйн хувьд Монгол Улс нь Төв Азийн зүүн хэсэгт Хойд Хятадыг ОХУ-ын Сибирьтэй холбодог бөгөөд манай улсын газар зүйн байрлалын ач холбогдол тодорхой хэмжээнд чухал ач холбогдолтой хэвээр байх болно.

Гэхдээ Монгол Улсын тээвэр-газар зүйн байрлалын ач холбогдлыг ОХУ-ын нутгаар өнгөрөх Транссибирийн төмөр зам, Казахстан, Хятадын нутгаар дайрах Казахстан-Шинжаан-Ганьсүгийн төмөр зам ихээхэн хэмжээгээр бууруулж байдаг. Гэхдээ хэтийн ирээдүйд хуурай газраар нэвтрэх асар их ачаа урсгалын тодорхой хэсэг Монгол Улсаар дайрах нь ойлгомжтой юм. Гэхдээ хоёр хөрш манай улсаар аль болох олон улсын тээвэр дайран өнгөрүүлэхгүй байлгахыг хичээн хамтарч ажиллах нь илэрхий байна.

Төв Ази нь Ази тивийн бусад бүх бүстэй зах нийлдэг бөгөөд үүгээрээ сүүлийн үед дэлхийн геополитик, гео-эдийн засагт чухал ач холбогдолтой болон хувирч байна. Хүснэгтээс үзэхэд Төв Ази нь улс төрийн хувьд нэгдмэл бүс болж чадаагүй байгаа ба Орос, Хятадын нөлөө бусад бүх улсаас илүү бүс юм. ЗХУ задарснаар Дундад Азийн 5 улс нь эдийн засгийн шинэ зах зээл болж дэлхийн зах зээлд гарч ирэв. Мэдээж шинэ зах зээл болон эрчим хүчний нөөц эзэмшихийн төлөө Төв Азийн хөрш Орос, Хятад, Энэтхэг гурнууд ба Турк, Иран, Пакистан зэрэг лалын том орнууд, дэлхийн их гүрэн АНУ, эдийн засгийн их гүрэн

Япон болон Европын холбоо зэрэг том улсуудын эдийн засгийн өрсөлдөөний талбар болон хувирч эхэлж байна.

Үндэстэн угсаатны болон шашны хувьд Төв Ази нь алаг цоог бүс бөгөөд энд шашны янз бүрийн урсгалуудын болон улс төрийн мөргөлдөөн үргэлжилсээр байна. Тус бүсийн уугуул суугчид нь бүгд нүүдэлчид бөгөөд түрэг, монгол, төвд, перс угсаатнуудын уугуул нутаг болдог. Шашны хувьд Төв Ази нь хүн амын олонхи нь лалын шашин шүтдэг, буддын шашны нөлөө ихтэй бусад олон шашны зааг болдог бүс нутаг юм.

1996 онд үүссэн ШХАБ нь тус бүсэд тэргүүлэх нөлөөтэй Орос, Хятад, Төв Азийн 4 орныг хамарсан бүс нутгийн томоохон олон улсын байгууллага бөгөөд үндсэндээ Орос, Хятадын хамтын ажиллагаанд Төв Азийн жижиг орнуудыг хамруулахаар байгуулагдсан гэж хэлж болохоор байгууллага юм. Олон улсын бүс нутгийн энэ байгууллагад Монгол Улс эрт орой ямар нэг хэмжээгээр холбогдож, хүссэн хүсээгүй оролцох цаг үе ирэх нь ойлгомжтой юм.

Энэ байгууллагатай огт хамтран ажиллахгүй байх нь манай улсын эдийн засгийн хөгжлийн эрх ашгийг хохироох сөрөг талтай юм. Иймд холбогдох судалгааны болон төрийн байгууллагууд энэ олон улсын байгууллагыг бүх талаар судалж, хэрэв хамтарч ажиллах буюу Монгол Улс гишүүнээр элсэх болвол ямар чиглэлээр оролцож, хэрхэн хамтарч ажиллавал Монголд хир ашигтай тусахыг урьдаас тодорхойлох хэрэгтэй юм. Бидний судалгааны гол үр дүн нь тохиолдож болох саад бэрхшээлийг урьдчилан тооцож стратеги бодлогыг тодорхойлсноор хүнд хэцүү байдлаас гарахад туслахад оршино. Гэхдээ бид ямарч судалгаа хийсэн бай ирээдүйд бий болох цаг үеийн байдлыг өөрчлөхгүй нь хэнд ч ойлгомжтой.

М.Батчимэг (Стратегийн Судалгааны Хүрээлэн (ССХ)-ийн ахлах судлаач): Төв Азид шинээр тусгаар тогтносон 5 орон төр улсаа гүйцэд төвхнүүлж амжаагүй, бодлого нь тодорхойгүй, улс төрийн дотоод зөрчил ихтэй хэвээр байна. Хөгжлийн чиг хандлага нь ч тодорхой бус байна. Одоогийн байдлаар эдгээр орнуудад бүгдэд нь авторитар засаглал ноёрхож байгаа бөгөөд улс төрийн хүрээнд сөрөг хүчний үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөөгүй, хүний эрх, эрх чөлөөг ноцтой хөсөрдүүлсэн, авилгал, хээл хахууль ихээхэн газар авсан байдалтай байна. Өрнөдийн орнууд, олон улсын байгууллагуудын шахалтаар зарим нэг арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа ч бүхэлд нь авч үзвэл Төв

Азийн орнууд ойрын хугацаанд ардчилсан шинэчлэл хэрэгжүүлж амжилт олох найдлага маш бага байна. Төв Азийн орнуудын эдийн засаг тогтворжоогүй хэвээр байна. Тусгаар тогтносноосоо хойш эдгээр улсууд гадаад орнууд, олон улсын байгууллагуудаас нийт хэдэн тэрбум доллараар тооцогдох тусламж, хөнгөлөлттэй зээл авсан ч, хээл хахуульд идэгдсэн тэдгээр хаалттай орнуудад тусламжийн хөрөнгө цөөн хүний халаасыг дүүргэж, эдийн засгийн өсөлт, жирийн иргэдийн амьдралд тодорхой үр нөлөө үзүүлэхгүй байна. Ядуурал, ажилгүйдэл нэн өндөр хэмжээнд хэвээр байхад баян хоосны ялгаа гүнзгийрч байгааг олон эх сурвалжуудаас олж үзэж болно. Төв Азийн бүс нутаг байгалийн нөөц баялаг ихтэй боловч түүнийг ашиглаж эхлэхийн тулд дэд бүтцийн салбарт асар их хөрөнгө оруулалт хийгдэх, үүний сацуу байгалийн баялгийг дагасан их гүрнүүдийн ашиг сонирхлын тэнцвэрийг хангах бэрхшээлтэй асуудал тавигдаж байгаа. Тэгээд ч байгалийн нөөц баялаг дангаараа хөгжил дэвшил, амгалан тайван амьдралын баталгаа болж чаддаггүйг Иракийн жишээ бидэнд харуулж байна.

Бүс нутгийн аюулгүй байдлын орчин ээдрээтэй хэвээр байна. Улс төр, эдийн засгийн хүндрэлүүдээс үүдээд 5 орны дотоод байдал нь угаас тогтворгүй байгаа. Үүн дээр гадаад харилцаа, аюулгүй байдлаа хангах асуудлаарх үзэл баримтлалын зөрүү, хилийн асуудал, байгалийн баялаг эзэмших, ашиглах талаарх маргаан зэрэг улс орнуудын хоорондын зөрөлдөөнт асуудлууд, лалын хэт даврагсдын бүс нутгийн хэмжээнд үзүүлж буй аюул занал гэх мэт тогтворгүй байдлын маш олон хүчин зүйл тус бүс нутгийг хямрааж байна. Эдгээрээс үүдэн манай хил залгаа Төв Азийн бүс нутаг нь улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын аль ч салбарт төлөвшиж тогтворжоогүй байгаа бөгөөд цаашид улс орнуудын ашиг сонирхлын тэнцвэрийг тодорхой хэмжээгээр хангасан бүс нутгийн тайван тогтвортой орчин, хөгжлийн чиг хандлага төлөвшихөд ихээхэн хугацаа шаардагдах болно гэж үзэж байна.

Төв Азийн геополитикийн онцлог ба их гүрнүүдийн ашиг сонирхлын хувьд авч үзвэл Орос, Хятадын зүгээс 2001 оны 9-р сарын 11-ний үйл явдлын дараа АНУ-ын цэрэг Төв Азид байрласан явдалд харьцангуй хүлээцтэй, ойлгосон байдлаар хандсан ч хугацаа өнгөрөх тусам энэ асуудалд улам эмзэглэх хандлага харагдаж байна. ОХУ-ын хувьд саяхан НАТО хаяагаа тэлсэн явдал бүр ч эмзэглэл төрүүлж байгаа. Хамтын Аюулгүй Байдлын Гэрээний механизм өнгөрсөн оны 3 -р сард Оросын идэвхитэй санаачлагаар Хамтын Аюулгүй Байдлын Гэрээний Байгууллага болон өргөжиж, нэгдсэн штаб, түргэн байрлуулах

хүчинтэй болсны зэрэгцээ Киргизстанд цэргийн нисэх хүчний бааз байгуулсан. ОХУ мөн одоо Тажикстанд цэргийн баазаа байгуулах асуудлыг тус улстай эрчимтэй зөвлөлдөж байна. БНХАУ-ын хувьд АНУ терроризмтэй тэмцэх нэрийдлээр бүс нутгуудад цэргээ удаан хугацаагаар суурьшуулж, нөлөөллөө бэхжүүлэхийг эрмэлзэж байна гэж нээлттэй шүүмжилж байгаа. Хятадад ч, Орост ч АНУ-ын цэргийн хүчинд бүслэгдэж байгаа талаарх эмзэглэл ихээхэн цухалзах болсон. Иймээс Төв Ази дахь их гүрнүүдийн харилцаа одоогоор харьцангуй хүлээзнэсэн, бие биеийн байр суурийг тандсан байдалтай байгаа ч дунд болон урт хугацаанд хурцдаж болзошгүй далд шинжийг агуулж байна. Ийм нөхцөлд Төв Азийн орнуудад явуулсан судалгаагаар Узбекстанаас бусад улсын иргэдийн дийлэнх нь бүс нутаг дахь Оросын нөлөөг сайшааж, АНУ-д сэжиглэсэн байр сууринаас хандаж байгааг зарим эх сурвалжууд өгүүлж байгаа юм.

Д.Бямбажав (Боловсролын Их Сургууль (БИС), докторант): Төв Ази хэмээх ойлголтын дор багтах таван улс дахь улс төрийн дэглэм, иргэний нийгмийн төлөв байдал бидний хувьд нэлээд сонирхол татаж байна. Нэгэн ижил гарааны цэгээс эхэлсэн эдгээр таван улс дахь улс төрийн дэглэмийн төлөвшил өрнөдийн судлаачдын нэрлэж буйгаар хагас авторитар, эсхүл хагас ардчилал гэдэг ойлголтуудын хүрээнд яригдах болжээ. Хэдийгээр ЗХУ задарч, түүний бүрэлдэхүүнд байсан улсууд тусгаар тогтносноос хойш хүний эрх, эрх чөлөө, хууль эрх зүйг тунхаглан зарласан ч эдгээр улсуудад засгийн эрх мэдэл нэг хүн, нэг намын гарт үндсэндээ төвлөрөх процесс үргэлжилж байна. Улс төрийн ба эдийн засгийн эрх мэдэл эрх баригчдын гарт төвлөрсөн нь хяналт, тэнцвэрийг үндсэнд нь үгүй болгосон дүгнэлт харагдаж байна. Эдгээр орнууд дахь ардчилсан үйл явцад гарсан мухардал, сөрөг талууд нь Монгол Улсын хувьд сургамж бүхий чухал асуудал гэдгийг онцлох хэрэгтэй. Монгол Улс эдгээр улсуудтай харьцуулахад ардчиллын замд хийх алхамд олон чухал ололт амжилтад хүрсэн хэдий ч өнөөдөр өрнөж буй улс төрийн үйл явцад бид дун шинжилгээ хийхдээ дээрх байдлыг анхааран үзэх нь чухал ач холбогдолтой болов уу. Эдгээр орнуудад иргэний нийгэм маш сул байна. Иргэний нийгэм бус харин иргэнлиг бус (uncivil) нийгмийн төлөөлөгчид Киргизстан, Тажикстанд засгийн эсрэг тэмцэл, халдлага явуулж байна. Калифорнийн их сургуулийн доктор С.Фишийн тайлбарласнаар Монгол ба Төв Азийн улс орнууд дахь ардчилалд харьцуулах, харилцан сургамж авах олон зүйл байна гэдгийг би ишлэж байна.

Төв Азийн 5 улсын талаархи товч мэдээлэл

	Казакстан	Узбекстан	Туркменистан	Киргизстан	Тажикстан
нутаг дэвсгэр (мян.км^2)	2 717	447	488	198.5	143
Хүн ам /сая хүн/	16.3	23.6	4.6	4.6	6.0
хүн ам, үндэстний бүрэлдэхүүн (сая)	52%	71,4%	77,0%	4.9 (2003. 7 сар) Киргиз 52.4%, орос-18%, узбек - 12.9%,	62,3%
Засаглалын хэлбэр, төрийн тэргүүн	Ерөнхийлөгч бүхий БНУ, Н.Назарбаев, (1991, 79.8%*)	Ерөнхийлөгч, Каримов, 1990, 92%	Ерөнхийлөгч, Ниязов, 1990, 95.5%	Ерөнхийлөгч бүхий БНУ, А.Акаев, (1990.X) дараагийн сонгууль – 2005 он	Ерөнхийлөгч, Рахмонов, 1992, 97%
Тусгаар тогтносон огноо	1991-12-16	1991-09-1	1991-10-27	1991-08-31	1991-09-09
ДНБ /тэрбум ам.долл	20.9	22.9	3.0	1.8	2.3
Нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ /долл/	1340	950	650	380	370
Нэг хүнд ноогдох ДНБ-ний хэмжээ худалдан авах чадвараар /долл/	4378	2053	2550	2317	1041
ДНБ-ний өсөлт /%/*	2.7	4.4	16.0	3.7	3.7
Инфляцийн түвшин /%/*	8.3	26.0	23.5	35.9	27.5
БНХАУ-тай хийж буй гадаад худалдааны нийт эргэлт	1557.0	51.5	16.2	177.6	17.2
БНХАУ-тай хийж буй экспорт	598.8	39.4	12.1	110.17	6.8
БНХАУ-тай хийж буй импорт	958.2	12.0	4.1	67.4	10.4
Нефтийн тогтоогдсон нөөц	2.2 тэрбум тн				
Байгалийн хийн тогтоогдсон нөөц	2.5 трлн. шоо. метр	2 орчим тэрбум м^3	3 тэрбум м^3		
Каспи дахь нефтийн нөөц /урьдчилсан судалгаагаар/	13 тэрбум тонн	0,3 тэрбум тонн	6,3 тэрбум тонн		
Каспи дахь байгалийн хийн нөөц /урьдчилсан судалгаагаар/	6 триллон м^3	2 триллон м^3	15,5 тэрбум м^3		
Хуурай замын цэрэг	100000	130000	16000	14000	24000
Цэрэгжсэн байгууллагуудад алба хаагчид	34000	19000	6000	3000	6000
Онгоцны тоо /ш/	221	200	35	34	42

О.Машбат (ССХ, докторант): Монгол Улсын Төв Ази дахь ашиг сонирхол юу вэ? Аливаа гадаад бодлого бол дотоод бодлогын үргэлжлэл байдаг. Манай гадаад бодлого ч мөн л Монгол Улсын хөгжил дэвшлийн гадаад таатай орчин бүрдүүлэхэд чиглэнэ. Ардчиллын тогтвортой байдал, хөрөнгө оруулалтыг татах, гадаад нэр хүндийг өргөх явдал бол манай гол зорилт, ашиг сонирхол болоод байна.

Чухам иймээс Монгол Улс нийгэм эдийн засгийн тогтолцооны шинэ шилжилт хийсэн 1990 оны эхэн үеэс эхлэн олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд Зүүн Хойд Азийн чиглэлийг гадаад бодлогын гол чиглэл болгон барьсан юм. Ардчилсан тогтвортой дэглэм, эдийн засгийн өндөр хурдтай өсөлт Зүүн Азид байсан нь манай улсын дотоод тогтвортой байдал, эдийн засгийн шинэчлэлд хувь нэмэр болж, хөрөнгө оруулалт татах эх сурвалж болсон билээ. Чухам иймээс л манай "гурав дахь хөрш"-ийн гэгдэх олон тулгуурт гадаад бодлого маань үр дүнтэй байсан, манай улсын хөгжлийн ашиг сонирхлыг ямар нэг хэмжээгээр хангаж чадсан юм гэж дүгнэж болох юм. Жил тутам гардаг Ази, Номхон Далайн аюулгүй байдлын тойм-ын 2003 оны дугаарт Монгол Улсын "Гуравдагч хөрш"-ийн тухай баримтлал нь ганц Өрнөдийн бус басхүү Зүүн Азийн орнуудыг багтааж байна. Өмнөд Солонгос, Япон зэрэг нь эдийн засгийн агуулгаараа гуравдагч хөрш бол, харин АНУ стратегийн хувьд, Энэтхэг соёлын хувьд хөрш болж байна хэмээн дүгнэсэн байна.

Олон талт яриа хэлэлцээний механизм бол жижиг орны аюулгүй байдал, ашиг сонирхлыг хангах гол механизм мөн. Монгол Улс ч геополитик, гео-эдийн засгийн хавчигдмал байдлаа даван туулах гол гарц бол олон талт яриа хэлэлцээрийн механизм мөн хэмээн үзсэн юм. Чухам иймээс Зүүн Ази, Ази-Номхон далайн бүс нутгийн олон улсын байгууллага, яриа хэлэлцээний механизмд элсэн орохыг идэвхтэй эрэлхийлсэн билээ.

Сүүлийн үед Монгол Улсаас Төв Азийн чиглэлд явуулах бодлого судлаач, эрдэмтдийн дунд нэлээд маргаан тарих боллоо. Энэ нь манай хөгжлийн болон аюулгүй байдлын ашиг сонирхлын бүс Зүүн Азиас Төв Ази руу шилжиж буй хэрэг биш юм. Харин олон улсын тавцанд өрнөж буй үйл явц Төв Азийн театрт идэвхжин, Төв Ази нь улс төрийн хувьд бүс нутаг болон төлөвших явц ид өрнөж байгаа нь энэ бүс нутаг дахь бодлогоо хөгжлийн болон аюулгүй байдлын ашиг сонирхлын үүднээс дахин тодорхойлох шаардлага гарч ирж байгаа юм.

Геополитикийг үндэслэгчдийн байр сууринаас Төв Азийг эргэн харахуй. Их Британийн сэтгэгч Маккиндер дэлхийн бодлого дахь

Евразийн ач холбогдлыг тодорхойлохдоо эх газрын "Амин нутгийг хэн эзэгнэнэ, тэрээр дэлхийг эзэгнэнэ" гэсэн зарчмыг тунхагласан юм. Мөн Карл фон Хаусхофер ч энэ талаар нэг санаа бодолтой байсныг түүний бүтээлүүдээс үзэж болно. Тэдний үзэж байгаа "Амин нутаг" нь өдгөө Төв Ази ба Сибирь гэсэн улс төрийн хоёр орон зайд аймаглаж болох юм. Энэ орон зай XVII зуунаас хойш хүйтэн дайны үеийг дуустал эхлээд Оросын, дараа нь Зөвлөлтийн эзэнт гүрний шууд харьяанд байсан.

Гэхдээ Маккиндерийнхээр бол энгүй уудам энэ газар нутагт холбоо харилцааны шуурхай систем тогтоосон улс л эх газрын эзэнт гүрэн гэсэн статусыг олж авдаг. XIII зууны Монголын эзэнт гүрэн морин өртөө байгуулсан нь тухайн үеийн холбоо харилцааны хамгийн дэвшилтэт систем байсан бол Транссибирийн төмөр замыг барьснаар Орос орон эх газрын гүрэн болсон юм. Энэ төмөр замын систем өдгөө ч стратегийн бодит ач холбогдлоо алдаагүй байгаа боловч мэдээллийн технологийн шинэ эринд асуудлыг өөрөөр харах хэрэгтэй байна. ОХУ Сибирийг хянаж байгаагаараа түүний эх газрын их гүрний статус тодорхойлогдож байна. ОХУ дотооддоо Алс Дорнодоос эхлэн жин нөлөөгөө алдаж эхлэхгүй бол энэ статус цаашид ч баттай хадгалагдах юм.

Харин Төв Азийн хувьд байдал өөрөөр эргэлээ. Төв Азийн бүх улс НАТО-ийн Энхийн төлөө түншлэл (ЭТТ) болон ШХАБ-д элссэн нь эл улс эх газрын хэсэг боловч далайн гүрний нөлөөнд орж байна.

Энэ бол survival interest –ын үүднээс асуудалд хандаж буй явдал мөн. Дөнгөж задраад буй ОХУ-ын хувьд төдийгүй дөнгөж шинээр тар улсаа зарлан тунхаглаад байгаа Төв Азийн орнуудын хувьд ч асуудалд энэ өнцгөөс хандах нь аргагүй билээ.

Үндсэн тоглогчдыг шинжлэх аваас их гүрнүүдийн ашиг сонирхол Төв Азид төвлөрөөд байна. Эдгээр ашиг сонирхлын олон талт хэлбэр манай хувьд ач холбогдолтой болоод байгаа юм. Геополитикийн сонгодог онолын цонхоор харж тоймловол, "нэг талаас далайн гүрний ашиг сонирхлын хэрэгсэл болсон НАТО, түүний ЭТТ, нөгөө талаас эх газрын гүрний ашиг сонирхлын хэрэгсэл болсон ШХАБ гэсэн олон талт яриа хэлэлцээний хоёр механизм оршин тогтнож байна, энэхүү эсрэгцсэн хоёр байгууллагын өрсөлдөөний дунд лалын тулгуур үзэл, терроризм, үндэстэн дамнасан гэмт хэргийн сүлжээ зэрэг аюулгүй байдлын хүчин зүйл сүлжилдэж байна" гэсэн ерөнхий зураг гарах юм.

Гэтэл ШХАБ-ын гишүүн 6 орны 5 нь, үүний дотор ОХУ өөрөө ЭТТ-ийн гишүүн юм. Аюулгүй байдлаа олон талт механизмаар хангаж буй улс орнууд ихэвчлэн олон талт механизмын аль нэгийг нь сонгон ордог уламжлалтай. Гэтэл ШХАБ-ын гишүүд НАТО-ын ЭТТ-д элсэн нь нэгдүгээрт, үүнийг геополитикийн сонгодог онолд тулгуурлан тайлбарлах боломжгүй болохыг, хоёрдугаарт, хэрэв геополитикийн сонгодог онолоор тайлбарлавал, ШХАБ аюулгүй байдлын олон талт хэлэлцээрийн хувьд сул байгааг харуулж байна.

Ян Антони зэрэг ажиглагчид: Хэдийгээр ШХАБ нь (Төв азийн) бүс нутаг дахь АНУ, Өрнөдийн нөлөөг тэнцвэржүүлэх Хятад-Оросын хэрэгсэл гэгддэг ч гишүүн улсууд нь Афганистан дахь террорист заналхийлэлд нэгдмэл бус байр суурьтай байсан нь тус байгууллагын санаа зовних зүйл болжээ гэж тэмдэглэсэн байна.

Тэгвэл үүнийг НАТО-ын гишүүн өрнөдийн орны судлаачид арай өөрөөр тайлбарладаг. НАТО бол хүйтэн дайны үеийн цэргийн эвсэл юм. Гэтэл хүйтэн дайн дууссnаас хойш НАТО цэрэг-улс төрийн эвсэл болон өөрчлөгдөж, аюулгүй байдлын уламжлалт бус хүчин зүйлсийг бүс нутгаас холуур шийдэх эрмэлзэлтэй болжээ. 1990-ээд оны эхэн үед НАТО-д тулгарч байсан бүх сорилт Өрнөд Европын хилийн гадна байсан юм. Тиймээс НАТО тэдгээр сорилтод хариу барьж аюулгүй байдлыг экспортлох уу эсвэл (хил дотроо үлдэж) аюул заналыг импортлох уу гэсэн сонголт хийх хэрэгтэй байв. Аюулгүй байдлыг экспортлох хамгийн сайн арга бол гишүүн болохыг хүсч, бэлэн байгаа, мөн Балканых шиг мөргөлдөөнд татагдан орж болзошгүй байгаа тийм орнуудыг эгнээндээ нэгтгэн, тогвортой байдлын бүсийг тэлэх явдал байлаа.

Түүний нэг хэрэгсэл нь ЭТТ мөн. ЭТТ нь Кавказ, Төв Азид гарсан мөргөлдөөнийг НАТО-ын гишүүн орнуудын аюулгүй байдлыг хөндөхөөс өмнө голомтонд нь дарахын тулд байгуулсан түншлэлийн механизм юм. Манай ашиг сонирхлын үүднээс НАТО ба ШХАБ-г харьцуулан үзье. Манай улсын хувьд хилийн чанадад цэргийн хүчээр хамгаалах ашиг сонирхол үгүй юм. Жижиг буурай орон олон улсын бодлогод идэвхийлэн оролцох чадавхи сул, харин ч их гүрнүүдийн бодлогод өртөмтгий байдаг. Эл өртөмтгий чанарыг багасгахад олон талт яриа хэлэлцээрийн механизм ач холбогдолтой билээ. Иймээс Төв Азийн бүс нутагт явуулах манай бодлогын нэг гол чиглэл нь олон талт яриа хэлэлцээрийн механизм мөн. Гэвч энэ бодлогын хүрээнд аль механизмд нь дагаж орвол зохистой талаар суурьтай дүн шинжилгээ хийх шаардлагатай.

НАТО-ШХАБ харьцуулах нь

НАТО-ийн ЭТТ	ШХАБ
Нэгдсэн зохион байгуулалт	Нэгдсэн зохион байгуулалт сул
Санхүүгийн баттай эх сурвалж	Санхүүгийн ядмаг эх сурвалж
Бие даан үүрэг гүйцэтгэх туршлагатай	Бие даан үүрэг гүйцэтгэх туршлагагүй

НАТО-ын ЭТТ нь бүрэлдэхүүний хувьд нэг талаас НАТО-ын гишүүн орнууд, үүний дотор АНУ, Их Британи, Франц зэрэг НҮБ-ийн Аюулгүйн зөвлөлийн 3 орон, түүнчлэн Герман, Итали зэрэг Европын томоохон улсууд, өмнө нь найрамдалт харилцаатай байсан зүүн европын зэрэг байгууллагын 50 гаруй жилийн нэгдсэн зохион байгуулалттай тогтвортой эвсэл, нөгөө талд, манай орны нөхцөл байдалтай зарчмын хувьд ижил Төв Азийн тулгар улсууд байна.

Төв Азийн эдгээр тулгар улсад үндэстэн бүрэлдэх явцыг нь ардчилсан, чөлөөт эдийн засгийн жамаар жолоодож, тогтвортой байдал бий болгох гэсэн зорилтыг ЭТТ тавьж байна. Дөнгөж бүрэлдэн буй эдгээр тулгар улсын дотоод ардчилсан тогтвортой байдал бий болгох нь Европын хувьд ч, Төв Азийн улсуудын хувьд ч ашигтай юм. Харамсалтай нь, Төв Азийн тулгар улсуудад хуучин коммунист дарга нарын тогтоосон ерөнхийлөгчийн гэгдэх дарангуй дэглэм нь өөрийн оршин амьдрах орон зайгаа оросын нөлөө, хятадын халхавчид хайж байгааг харахгүй байх аргагүй юм. Өөрөөр хэлбэл, Төв Азийн улсуудын дотоод дэглэм нь нэг талаас, өрнөдийн улсуудаас ашиг сонирхлын наймаа хийж хөрөнгө оруулалт татах, нөгөө талаас, дэглэмийнхээ тогтвортой байдлын улс төрийн баталгааг Орос, Хятад зэрэг авторитари засаглалтай улсад түшиглэн хангах хоёр бодлогын дунд зогсож байна.

ШХАБ-ын гишүүн улсуудын дотоод дэглэм, эдийн засгийн байгуулал, үйл ажиллагааны журам нь манай тогтвортой ардчилал, хөрөнгө оруулалт, гадаад нэр хүндээ өргөх ашиг сонирхолд нэг л нийцэхгүй байгаа юм.

Нөгөө талаас, ШХАБ-ын бүрэлдхүүнийг харвал дан авторитари засаглалтай улсууд байдаг. Дундад Азийн шинэ тулгар улсуудад ардчилагдах явдал аль хэдийн саатаж, авторитари дэглэмтэй боллоо гэж судлаачид үздэг. Жишээ нь: Томас Каротер Шилжилтийн тухай үзэл бодлын төгсгөл (Das Ende des Demkmodells Uebergang) гэх бүтээлдээ 1990-ээд оны дундуур Самуэл П.Хантингтоны бичсэн Ардчиллын гуравдахь давалгаа (The Third Wave of Democracy) –д туссан

өөдрөг итгэл тэмүүлэл эцэс болсныг дүрслэн өгүүлсэн юм. Бид тодорхой улс орнуудыг дарангуй дэглэмээс ардчилал руу шилжиж байна хэмээн ярьж бичдэг боловч шилжилт хэзээ дуусах вэ гэдгийг мэдэхгүй л байна. Харин Каротер шилжилт нэгэнт дууссан бөгөөд сонгууль зэрэг ардчиллын элементтэй мөртлөө ардчилсан бус дэглэм бүхий улсууд бодитойгоор бий болжээ гэж үзсэн байдаг. Үүнийгээ саарал бүс хэмээн нэрлэсэн байх ба *саарал бус*-т байгаа улс төрийн янз бүрийн дэглэмийн нэг нь die Politik einer berherrschenden Macht буюу эрх мэдэл хэт төвлөрсөн (авторитари маягийн) улс төр юм.

Төв Азийн эдгээр дэглэм нь алсдаа улс төрийн хувьд тогтвортой байж чадахгүй. Хамгийн наад зах нь эдгээр улсын удирдагч нарын халаа сэлгээний асуудлаар гэхэд нэлээдгүй маргаан гарах нь лавтай байдал үүслээ. Саяхан Азербайжаны ерөнхийлөгч Гайдар Алиев нас нөгчихдөө хүү Илхан Алиевт ерөнхийлөгчийн суурыа уламжлан үлдээсэн нь Төв Азийн бусад улсад иймэрхүү зүйл болох вий гэсэн болгоомжлолыг дэлхий нийтэд төрүүлж байна.

Иймээс Монгол Улсын Төв Азийн бүс нутаг дахь бодлогоо тодорхойлохдоо Ардчиллыг бататгах, эдийн засгийн хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаад нэр хүндээ дээшлүүлэх үндсэн зорилтоо тууштай барьж, тун болгоомжтой хандах нь зүйтэй юм.

М.Хурметхан (ОУСХ-ийн ЭШТА, Sc.D): Төв Азийн газрын тос, байгалийн хийн асуудал–Каспийтэй гүн холбоотой. Каспий гэдэг нь грек хэлэнд Kaspian pelagos, латин хэлэнд Caspium Mare бөгөөд эртний жинхэнэ нэр нь Хазарын тэнгис юм. Их далайгаас таслагдсан хамгийн том давст нуур - урт нь 1200 км, өргөн 320 км, талбайн хэмжээ нь 371 мян.км^2 /1929 онд 422 мян.км^2 / байна.

Каспий тэнгис юм уу, нуур юм уу гэдэг дээр нэлээд асуудал оршиж байдаг. Хэрвээ түүнийг задгай далайгаас тусдаа байгааг анхаарвал Каспийг нуур хэмээн үзэх ёстой. Ийм нөхцөлд түүнийг тойрон оршдог 5 улс нуурын суурь дэвсгэрийг секторoор хуваах нь зүй. Хэрвээ тэнгис хэмээн тооцвол, олон улсын хуулийн дагуу эргийн улсуудад 21 мян.км орчим нутаг оногдож, үлдсэн нь олон улсын бүсэд хамаарагдана. Америкийн судлаачид түүний ёроолд 200 тэрбум баррель газрын тос байгааг тогтоосон нь олон улс орон Каспийг сонирхоход нөлөөлсөн байна. Өнөөг хүртэл тэнгисийг секторoор хуваасан ЗХУ-ын үеийн хуулийг баримталж байгаа юм. Энэ талаар авч үзвэл хамгийн том сектор нь Казахстанд оногддог. Түүний дараа Азербайжан, Туркместан, ОХУ ордог. Каспийн бага хэсэг нь Иранд ноогддог. Одоо Каспийн нөөцийг адил тэгш хуваах асуудал яригдаж байгаа юм.

АНУ-ын засаг захиргааны гадаад улс төрийн бодлогод Каспийн тэнгисийн асуудал тэргүүн байр эзэлж, Каспийн эрэг орчмын орнуудад Америкийн компаниудын ашиг сонирхол идэвхтэй өсөн нэмэгдэж байна. Үүнд бас барууны орнуудын Ойрхи Дорнодын эрчим хүчний эх сурвалжаас үл хамаарах хүсэл эрмэлзэл, газрын тосны гол нийлүүлэгчдийн хоорондын өрсөлдөөн нэмэгдсэн, Каспийн газрын тосны нөөцийг ашиглаж эхэлсэн зэрэг нь нөлөөлж байна.

Тиймээс Каспийн газрын тосны нөөцийн төлөө АНУ, ОХУ, БНХАУ, ЕХ, Турк, Иран, Персийн булангийн орнууд зэрэг "хүчний төвүүд" өрсөлдөх бололтой. Энэхүү бүс нутаг нь геополитикийн үүднээс авч үзвэл, умард-өмнөд, дорнод-өрнөд рүү гарах "геополитикийн үүд" гэж хэлж болох тул тус бүс нутгийн стратегийн тогтвортой байдал нь геополитикийн хүчний тэнцвэрээс ихээхэн хамаарах юм.

Тус бүс нутагт газрын тос, байгалийн хийн экспортын талаархи өрсөлдөөн явагдаж байна. Каспийн газрын тос, хий дамжуулах хоолой ОХУ-аар дамждаг тул энэхүү чухал судсыг Орос улс гартаа атгаж байхыг эрмэлзэж, нөгөө талаас үүнийг өөрчлөхийг ихэд чармайж байна.

Казахстан 2010 он гэхэд дахиад нэг газрын тос дамжуулах хоолой барьж магадгүй. Мөн Европын орнуудыг дамжин, шууд Адриатын боомт хүртэл г.м хоолой барих төсөл бий. Мөн Хар тэнгисийн доогуур Турк руу "цэнхэр урсгал" хэмээх хоолой барих төсөл ч байна. АНУ нь Баку-Жейханы хоолойн барилгын төслийг санхүүжүүлсээр байна.

Өнөөгийн байдлаар Каспийн нефть олборлолтын хэмжээ дэлхийн олборлолтын 1,5%, Ойрхи дорнодын 4%-ийг эзэлж байна. 2010 он гэхэд Каспийн олборлолтын хүчин чадал 150-200 сая.тонн болж, тухайн үеийн Ойрхи Дорнодын хүчин чадлын 12%-тай тэнцэнэ. Одоо Каспийн нефть, байгалийн хийн нийт олборлолтод гадаадын 40-өөд компани /АНУ 11, Япон 5, Их Британи 4, Франц 3, Турк 3, Иран 2, Итали 1, Герман 1 гэх мэт/ оролцож байна.

2025 он гэхэд эрчим хүчний уламжлалт эх үүсвэр байр сууриа алдаж, нефтийн хэрэглээ багасна. Иймээс 20-30 жил нефть ашиглах орон зай байх тул нефтийн зах зээлийн төлөө явагдаж буй өнөөгийн өрсөлдөөн цаг зуурын бөгөөд дэлхийн бүс нутгийн стратегийн тогтвортой байдалд ахар богино хугацаанд үйлчлэх тул томоохон өөрчлөлт оруулахгүй юм.

Д.Шүрхүү (ОУСХ, PhD): Сүүлийн жилүүдэд, ялангуяа 2001.09.11-ний террорист халдлагаас хойш Төв Азийн бүс геополитикийн болон геоэдийн засгийн хувьд их гүрнүүдийн анхаарал сонирхлыг ихээр татах болсон бөгөөд зарим тохиолдолд тэдний эрх ашиг эрс зөрөлдөх болсон билээ. Төв Ази дахь их

гүрнүүдийн ашиг сонирхол гэдэгт маш олон зүйлийг хамруулж болох боловч хамгийн амин чухал чиглэл бол хоорондоо нягт уялдаа холбоо бүхий цэрэг–стратегийн байр суурь, оролцоогоо нэмэгдүүлэх, эрчим хүчний эх сурвалжид хяналт нөлөөгөө бэхжүүлэх гэсэн 2 асуудалд төвлөрч байна.

Тэгвэл их гүрнүүдийн амин чухал эрх ашгийн бүс хэмээн зарлаад буй Төв Азийн бүс нутаг стратегийн чухал түүхий эд болох газрын тос, байгалийн хийгээр хэр зэрэг баян вэ гэдэг асуудал аяндаа гарч ирнэ. Мэдээллийн эх сурвалжаас хамааран янз бүрийн тоо баримт байна.

ОХУ, Казахстан, АНУ-ын мэргэжилтнүүд Казахстаны газрын тосны хайгуулын нөөцийг 3.5–15 тэрбум тн., тогтоогдсон нөөцийг 2-3.2 тэрбум тн хэмээн тодорхойлсон бөгөөд энэ үзүүлэлтээр дэлхийд 13-р байрт орж байна. Казахстан одоо 50 сая тн газрын тос олборлож байгаа ба 2010 онд 100 сая тн-д хүргэхээр төлөвлөж байна. Харин Туркменистаны хувьд газрын тосны нөөц Оросын талын тооцоогоор 1.5 тэрбум тн гэж үзсэн бол америкууд 5 тэрбум тн хэмээн тоймлосон байна. Харин туркмений тал 12 тэрбум тн гэж үзэж байгаа боловч одоогоор нөөц 300 сая тн орчим ажээ. Гэхдээ Туркменистаны гол найдлага бол байгалийн хий бөгөөд одоогоор дэлхийд олборлолтын хэмжээгээр 4-рт, экспортоор 2-рт орж байна. Туркменистан, Казахстан, Узбекистаны нотлогдоод буй байгалийн хийн нөөц тус бүрдээ 2- 3 триллион шоо м тул нийтэд авч үзвэл дэлхийд эхний тавд орох боломжтой юм. Хэрэв Төв Ази, Каспийн тэнгис орчмын нутгуудын газрын тос, байгалийн хийн нөөцийг хамтад нь авч үзвэл ойрын ирээдүйд дэлхийн эрчим хүчний нэлээд чухал эх сурвалж болох төлөв байдал ажиглагдаж байна.

Газрын тосны дэлхийн баланс

(2002-2003 оны байдлаар)

	Нөөц (тэрбум баррель)	Олборлолт (сая баррель / өдөр)	Хэрэглээ (сая баррель / өдөр)	Импорт (сая тн) (сая баррель/ өдөр)
АНУ	2.2% (22.7)	9.9% (9.1)	25.4% (9.1)	26% (9.1)
ОХУ	6% (60)	10.7% (8.4)	3.5% (2.7)	-
Ойрхи Дорнод	65.4% (685.6)	28.5% (26)	5.9% (5.1)	-
Баруун Европ	1.7% (18.2)	4.1% (9.1)	18%	23%
БНХАУ	1.7% (18.3)	4.8% (3.2)	7.4% (4.6)	(1.4)
Төв Ази (Каспийн сав газрын хамт)	1.6 % (17)	2.4% (1.6)	-	-
Зүүн Ази/ Япон, БНСУ, Тайвань/	-	- (0.2)	11% (8.4)	11% (8.3)

Дээрх хүснэгтээс Төв Ази, Каспийн орчим нутаг одоохондоо газрын тосны дэлхийн балансад төдийлөн нөлөө байхгүй нь харагдаж байгаа боловч эрчим хүчний аюулгүй байдлаа бататгах үүднээс эх сурвалжаа аль болох олон сувагтай болгохыг чармайж буй АНУ, Европ болон Азийн зарим орнуудын анхааралд улам бүр орох болсон юм.

Хэдийгээр Төв Ази болон Каспийн сав нутагт эрчим хүчний ихээхэн нөөц илэрсэн боловч далайд шууд гарцгүй, дэд бүтэц сул, ажиллаж буй хоолойнууд гол төлөв ОХУ-аар дамжин гардаг зэрэг хүчин зүйлээс хамааран түүнийг дэлхийн зах зээлд хүргэх асуудал газрын тос, хийг олборлохоос ч илүү чухал геополитикийн асуудал болон хувирсан билээ. Чухамдаа хэн дамжуулах хоолойнуудад хяналтаа тогтоож чадна тэр энэ бүс нутгийн эрчим хүчний эх сурвалжид хяналт, нөлөөгөө бэхжүүлэх нь тодорхой болсон юм.

Төв Ази, Каспийн тэнгисийн газрын тос, хийн экспортын чиглэл

Чиглэл	Дамжуулах чадал	Урт	Хөрөнгө оруулалт	Одоогийн байдал
Атырау (Казахстан) - Самара (ОХУ)	өдөрт 310,000 баррель газрын тос	695 км	$37.5 сая	Жилд 15 сая тн тос дамжуулах чадалтай болгоод байна
Баку- Тбилиси - Жейхан (Турк)	Өдөрт 1 сая баррель газрын тос	1670 км	$2.9 тэрбум	2005 оны эхээр ашиглалтанд орно.
Баку-Супса(Гүрж)	Өдөрт 300,000-600,000 баррел тос	828 км	$600 сая	1999 онд ашиглалтанд орсон.
Баку-Новороссийск	Өдөрт 100,000-300,000 баррел.	1396 км	$600 сая	1997 оноос ашиглалтанд орсон.
Тэнгиз- Новороссийск (Каспийн Хоолойн Консорциум)	Өдөрт 565,000 баррель цаашдаа1.34 сая баррелд хүрнэ	1592 км	$2.5-4.2 тэрбум	2001 оны эцсээр ашиглалтанд орсон.
Атасу (Казахстан)- Алашанькоу (БНХАУ)	Жилд - 10 сая тн газрын тос цаашдаа - 30 сая тн	988 км	$600 сая	2005 оны эцсээр ашиглалтанд орно.
Дундад Ази – Төв (Хуучин Найрамдал)	Жилд: 45 тэрбум шоо метр хий			ЗХУ-ын байгуулсан Одоо Газпром -ын хяналтанд байдаг
Баку-Тбилиси-Эрзерум(Турк)	Жилд: 7.1тэрбум шоо метр	868 км	$1 тэрбум	2005 оны эцсээр ашиглалтанд орно.
Корпезхи(Туркменистан)-Күрт-Күйн(Иран)	Жилд: 7-9 тэрбум шоо метр байгалийн хий	200 км	$190-300 сая	1997 оны 12 дугаар сард ашиглалтанд орсон.

Эх сурвалж ://www.eia.doe.gov/emeu/cabs/caspian.html.

Шинээр тусгаар тогтносон Төв Азийн орнууд (ТАО) болон хөрөнгө оруулж эхэлсэн өрнөдийн томоохон компаниуд ч ОХУ-ын нөлөөг бууруулах, хоолойн тээврийн альтернатив хувилбарыг сонгохыг

чармайж байв. Энэ нь юуны өмнө газрын тосны Баку-Тбилиси-Жейхан (Турк), хийн Баку-Тбилиси-Эрзерум (Турк) хоолойтой холбоотой юм. Мөн түүнчлэн монголчууд бид сүүлийн хэдэн жил нутаг дээгүүрээ дайруулах талаар ярьж хэлэлцдэг байсан Ангарск-Дацины газрын тос дамжуулах хоолойн асуудлыг 2003 оны намар ОХУ-ын тал "экологийн үнэлгээ"-г нягтлан судлах шаардлага гарсан хэмээн тодорхойгүй хугацаагаар хойшлуулсны дараа БНХАУ нь Төв Азиас хоолойгоор газрын тос авах ажилдаа яаравчлан орсон юм. Энэ оны 5-р сарын дундуур Казахстаны Ерөнхийлөгч Н.Назарбаев БНХАУ-д айлчлах үеэр уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхээр хоёр тал тохиролцоонд хүрчээ.

Ийнхүү 1990-ээд оны дунд үеэс, ялангуяа 2003 онд В. Путин ОХУ-ын төрийн тэргүүн болсон үеэс хуучин ЗХУ-ын нутаг дэвсгэр буюу ТУХН-ийн орнуудыг ОХУ-ын амин чухал эрх ашгийн бүс хэмээн зарлаж, уламжлалт геополитикийн орон зайгаа алдахгүйн тулд бодлого үйл ажиллагаагаа идэвхижүүлснээс хойш их гүрнүүдийн ашиг сонирхол Төв Ази дахь "эрчим хүчний геополитик" болон "дамжуулах хоолойн геополитик"-ийг тойрон эрс зөрчилдөж эхэлсэн билээ. Сүүлийн үеийн зарим жишээ баримтаас дурьдвал, 2003 оны 10-р сард ОХУ-ын ерөнхийлөгч В. Путин Екатеринбург хотноо Германы канцлер Г.Шройдертой уулзах үеэрээ ОХУ хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан БНУ-уудын нутаг дэвсгэр дээрх хий дамжуулах хоолойнууд дахь хяналтаа найр тавьж өгөх бодолгүй байгаагаа ил тод мэдэгдсэн юм. Туркменистан, Казахстан, Узбекистанд зөвлөлт засгийн үед барьсан хийн хоолойнуудын сүлжээнүүдийн найдвартай ажиллагааг гагцхүү ОХУ хангах бололцоотой, үүний тулд Москва тэдгээрийг өөрийн хяналтандаа байлгах шаардлагатай гэжээ.

Харин АНУ саяхан Каспийн эрчим хүчний асуудал эрхэлсэн томоохон түшмэл С.Манныг Гүрж, Азербайжан руу илгээж ОХУ-ын байгалийн хийн монопол компани болох "Газпром"-той Турк руу байгалийн хий нийлүүлэх талаар хамтран ажиллах тухай төлөвлөгөөгөө эргэн харахыг тус хоёр орны эрх баригчдаас шаардсан байна. Москва өнгөрсөн жил Турк хүртэл барьж дуусгасан боловч бараг ашиглагдахгүй байгаа хий дамжуулах "Цэнхэр урсгал" хоолойг одоо барих гэж буй Баку-Тбилиси-Эрзерум (Турк) хийн хоолойн оронд Азербайжаны "Шах-дениз"-ийн хийн ордоос Турк болон Европ руу байгалийн хийг экспортлоход ашиглахыг санал болгосон ажээ. Энэ

нь ОХУ-ын хийн салбар дахь монопол байдлыг улам бэхжүүлэх ажээ. Тэрбээр хэлэхдээ, Өрнөдийн зах зээл зөвхөн хийн нэг хоолойг хүлээж авах бөгөөд тэгээд ч Азербайжан байгалийн хийгээ экспортлохын тулд өөрийн бие даасан хий дамжуулах системтэй болохоосоо татгалзан бусдын хяналтанд буй хоолой руу очих шаардлагагүй хэмээжээ. Удалгүй Азербайжан Оросын саналаас татгалзсан тухайгаа албар ёсоор мэдэгдэв.

"Хүйтэн дайн"-ы төгсгөл, ЗХУ-ын задралаар Төв Азид стратегийн ач холбогдол бүхий сул орон зай үүссэн билээ. Энэхүү геополитикийн шинэ орон зайд нөлөөнийхөө хүрээг тэлэхийг эрмэлзсэн улс гүрнүүд ил далд өрсөлдөж эхэлсэн билээ. Сүүлийн жилүүдэд олон улсын терроризм, глобалчлал, уг бүс нутгийн газрын тос, хийн баялаг нөөцийг ашиглахтай холбогдон дээрх өрсөлдөөн цэрэг-стратегийн салбарт ч идэвхижих, бүс нутгийг улам бүр милитаричлах хандлага руу татан оруулах болсон билээ. Үүний нэг илрэл 2001 оноос хойш их гүрнүүд Төв Азид цэргийн баазаа байгуулах, зэвсгийн наймааны шинэ зах зээлээ болгох сонирхол эрс нэмэгдэж байгаа явдал юм. АНУ-ын хувьд 1999 онд Төв Ази, Кавказыг түүний зэвсэгт хүчний төв бүлэглэлийн командлалын (CENTCOM) "хамаарах бүс"-д оруулж, улмаар 2001 онд Афганистанд явуулсан "Сөхөршгүй эрх чөлөө" цэргийн ажиллагаатай холбогдуулан Узбекистанд (хуучин зөвлөлтийн цэргийн нисэх буудал байсан Каршид цэргийн бааз байгуулсан юм. Баруунд одоо түүнийг Ханабад гэдэг бөгөөд 2000 гаруй цэргүүд байрлаж байна), Кыргызстанд (НАТО-гийн хүрээнд Бишкекийн олон улсын нисэх буудал Манаст цэргийн нисэх хүчний бааз байгуулж, одоо 1800 гаруй цэргүүд байрлаж байна), Казахстан, Тажикстан, Гүрж, Азербайжантай агаарын орон зай, нисэх буудлыг ашиглах тохиролцоонд хүрсэн билээ. НАТО өөрийн бодлого, чиглэлийн дагуу Төв Азид идэвхитэй үйл ажиллагаа явуулж, Энхийн төлөө түншлэлд Төв Ази, Кавказын бүх орныг татан оруулаад байна. Герман улс мөн Узбекистанд афганы хилийн ойролцоо Термезэд цэргийн баазаа байгуулсан юм. Одоо Афганистанд АНУ-ын 11 000 гаруй, НАТО-гийн 6500 гауй цэрэг байрлаж байна.

Харин ОХУ-ын хувьд олон улсын терроризмтай тэмцэх зорилгоор АНУ, НАТО-тай цэргийн салбарт хамтран ажиллах хүрээнд АФганистаны дайнаас хойш өөрийн эрх ашгийн бүс болох ТУХН, ялангуяа Төв Ази, Кавказд цэргийн үйл ажиллагаа явуулах боломж

олгосон билээ. Гэвч АНУ-ын цэргийн оролцоо түр зуурын байдлаас нэлээд урт хугацааны шинжтэй болох тал руу эргэж, цэрэг-стратегийн чухал орон зайгаа, санаачлагаа алдаж эхэлснээ мэдмэгц ОХУ-ын эрх баригчид Төв Ази дахь цэргийн оролцоогоо нэмэгдүүлэх талаар улс төр дипломатын бодлогоо идэвхижүүлсэн билээ. Үүний үр дүнд ОХУ 2003 оны 10-р сард Кыргызстаны нийслэл Бишкекийн ойролцоо Кантад анхны гадаад дахь цэргийн баазаа нээсэн юм. Оросын улс төр, цэргийн удирдлага Кант дахь агаарын цэргийн бааз нь ОХУ-ын Төв Ази дахь эрх ашгийг хамгаалах хүчирхэг цайз болох бөгөөд хэрэв "шаардлага гарвал урьдчилан сэргийлэх үүднээс ТУХН орнуудад цэргийн хүч хэрэглэх" зарчмаасаа татгалзаагүй гэдгээ ч мэдэгдсэн юм. Мөн түүнчлэн ОХУ Тажикистан дахь 201-р дивиз, тажик-афганы хилийг хамгаалж буй хилийн цэрэг, пуужингийн довтолгооноос хамгаалах зорилгоор зөвлөлт засгийн үед байгуулсан сансрын ажиглалтын станцын асуудлыг шийдвэрлэхээр идэвхитэй яриа хэлэлцээ хийж байна. АНУ-ын зүгээс хүний эрх, ардчиллыг нухчин дарж буй талаар сүүлийн үед нэлээд шахалтанд орж буй Узбекистантай Оросын эрх баригчид идэвхитэй яриа хэлцээ хийж байна. Энэ бүхнээс дүгнэж үзэхэд ОХУ Төв Азид явуулж буй цэрэг стратегийн бодлогоо улам идэвхитэй, улам хатуу бодлого баримтлах болсон байна.

БНХАУ-ын хувьд хоёр талын болон ШАХБ-ын хүрээнд Төв Ази дахь цэргийн оролцоогоо нэмэгдүүлэх арга замыг идэвхийлэн эрэлхийлж байна. Гэвч Төв Азийн орнуудын уламжлалт Хятадаас болгоомжлох орчин, ОХУ, АНУ–ын ил далд эсэргүүцлийн улмаас Хятадын цэргийн тэлэлт одоохондоо ихээхэн хязгаарлагдмал байна.

Харин Төв Азийн цэрэг-улс төрийн геополитикт идэвхитэй оролцох сонирхолтой том тоглогч бол Энэтхэг юм. Энэтхэгийн хувьд Тажикистанд байгуулсан цэргийн бааз нь зөвхөн эхлэл бөгөөд Төв Азийн орнуудтай цэрэг-зэвсэг техникийн салбарт харилцаагаа өргөжүүлсээр байгаа нь иймэрхүү баазын тоо нэмэгдэх боломжийг нэмэгдүүлэх болно. Хятад, Энэтхэг хоёр цэрэг стратегийн томоохон өрсөлдөгч нар болохын зэрэгцээ Төв Ази, Ойрхи дорнодын ердийн зэвсэг техникийн наймааны зах зээлд хүчтэй өрсөлдөгч болох магадлалтайг шинжээчид таамаглаж байна. Энэтхэг-Ираны хооронд цэргийн салбарт харилцаа өргөжүүлж байгаа нь судлаачдын анхаарлыг ихэд татаж байгаа юм. 2003 оны 1-р сарын 19-нд байгуулсан Энэтхэг-Ираны цэргийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрт хоёр тал харилцан зэвсэг техник нийлүүлэх, шинэчлэх,

мэргэжилтнүүдээ солилцох, цэргийн салбарт харилцан дэмжлэг туслалцаа үзүүлэх олон зүйл тусгасан ажээ.

Хэрэв цаашид их гүрнүүд газрын тосны геополитик, стратегийн байр суурыа бэхжүүлэх ашиг сонирхлын үүднээс цэргийн оролцоогоо нэмэгдүүлбэл Төв Азийн байдлыг ихээхэн эмзэг, тогтворгүй, магадгүй шинэ "хүйтэн дайн"-ы голомт болгох ихээхэн магадлалтай байна.

С.Оюунцэцэг (ССХ-ийн судлаач): Хүйтэн дайны дараагаар олон улсын харилцаанд нэг улсын аюулгүй байдал нөгөө улсынхаа аюулгүй байдлаас хамаардаг хамаарал нь улам бүр ихсэв. Улс бүр дангаараа өөрийн аюулгүй байдлыг хангана гэдэг нь өнөөгийн нөхцөлд ихээхэн учир дутагдалтай болсон тул хамтын хүчээр олон талын хамтын ажиллагааны механизмыг бий болгох замаар аюулгүй байдлаа хангах нь даяаршиж буй нийгмийн нэг өвөрмөц онцлог болж байна. Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улс орнуудад, тэр дундаа өнөөгийн шинэ Төв Азийн бүс нутагт хамтын хүчээр шийдвэрлэвэл зохих асуудлууд тусгаар тогтнолтой нь зэрэгцэн гарч ирснээр тэднийг бүс нутгийн нөлөө бүхий улс оронтой хамтран олон талт хамтын ажиллагааны механизмыг байгуулахад, тэр дундаа Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллага (ШХАБ)-ыг байгуулахад гол түлхэц болжээ. ШХАБ нь анх БНХАУ, Казахстаны шургуу санаачлага, ОХУ-ын идэвхтэй дэмжлэгтэйгээр үүсэхдээ хилийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд үүсэж хилийн бүс дэх итгэлцлийг бэхжүүлэх, хилийн бүс дэх цэргийнхээ тоог харилцан хорогдуулах гэх мэт хилийн салбар дахь асуудлыг шийдэж байсан бол өнөөдөр улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн байгууллага болон төлөвших шатандаа яваа бүс нутгийн хэмжээний олон талт механизм болсон байна.

Төв Азид аюулгүй байдлын олон талт хамтын ажиллагааны механизм үүсэхэд дараах хүчин зүйл голлон нөлөөлжээ. Үүнд:

– Хилийн асуудал - Түүхэн учир шалтгааны улмаас Орос, Хятадын хооронд удтал оршиж байсан газар нутгийн маргаан нь шинээр тусгаар тогтносон Төв Азийн улсуудын аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болохоор байв. Нөгөөтэйгүүр Төв Азийн улсуудын өөр хооронд нь ч газар нутгийн маргаан үүссэн нь аюулгүй байдлаа хангахад нэгдэн тэмцэх эхлэлийг тавьсан.

- Дотоодын үндэстэн хоорондын зөрчил ихтэй байдал – Хуучин ЗХУ-ын үед хүчээр бий болгосон хил хязгаар нь ЗХУ-ын задралын дараа хэвээр хадгалагдан үлдсэнээр үндэстний хувьд маш их холилдож, бүс нутгийн улсуудын хоорондох маргааны нэгэн гол омтыг үүсгэхэд хүргэв.
- Терроризмын аюул - Тусгаар тогтносны дараагаар Осама бин Ладен болон Талибанаас санхүүждэг шашны фундаменталист, экстремист үзэлтнүүд өсөн нэмэгдэж, алан хядах үйл ажиллагаа явуулах нь эрчимжсэн.
- Их гүрнүүдийн ашиг сонирхол Төв Азийн бүсэд идэвжсэн. Дээр дурдсан гурван шалтгаанаас илүүтэйгээр Орос, Хятадыг түгшээсэн зүйл бол Төв Ази дахь АНУ-ын нөлөө өсөн нэмэгдсэн явдал байлаа. Ялангуяа 2001 оны 9-р сарын 11-ний үйл явдлын дараагаар Төв Ази дахь АНУ-ын сонирхол үлэмж ихэссэн. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга К.Пауэл 2002 оны 2-р сард Конгрессын төлөөлөгчдийн танхимын олон улсын харилцааны хорооны хуралдаан дээр хэлсэн үгэндээ "АНУ, Төв Азид урьд нь хэзээ ч ийм ач холбогдол өгч байгаагүй бөгөөд цаашид ч, бидний ашиг сонирхол, оролцоо хэвээр үргэлжлэх болно" гэж онцлон тэмдэглэж байв. Нөгөө талаас Орос, Хятад хоёр ч өөрсдийн ашиг сонирхлын бүс нутаг дахь АНУ-ын нөлөөг бууруулан хүчнийхээ тэнцвэрийг хадгалан үлдэхийн тулд ШХАБ-ыг ашиглах сонирхол ихсэв. Бас бүс нутагтаа тэргүүлэх чиг баримжаа барьж буй Казахстаны бодлого ч үүнд дэм болж өгөв. Тиймээс АНУ-ын ашиг сонирхол Төв Азид хэдий чинээ их эрчимжинэ төдий хэмжээгээр Орос, Хятад хоёрыг ШХАБ-ын хүрээнд нэгдэн нягтрах үйл явцыг идэвхжүүлэх хандлагатай болгох нь дамжиггүй.

Дээрх дөрвөн зүйлээс хамааран Төв Азид ШХАБ хэмээх олон талт механизм үүссэн бөгөөд цаашдын оршин тогтнох үндэс ч үүнтэй нягт холбогдох болсон. Ялангуяа нэг талаас терроризмын аюул өсөн нэмэгдэж буй нь Төв Ази дахь АНУ-ын оролцоог хурцалж, нөгөө талаас Төв Азийг их гүрнүүдийн сонирхлын мөргөлдөөний талбар болгож байна. Үүнтэй уялдаад ШХАБ нь Төв Азид олон талын хамтын ажиллагааны механизм болж чадах уу гэдэг асуудал гарна. Үүнд хариу өгөх үүднээс ШХАБ үүссэн 1996 оноос хойш болсон үйл явдлуудыг нэгтгэн дүгнэвээс эерэг, сөрөг байдал анзаарагдаж байна.

Эерэг зүйл:

- 2001 оны 6-р сард болсон дээд хэмжээний уулзалтаас анх удаа байгууллагынхаа зорилгыг тодорхойлов. Үүнд: "Гишүүн орнуудын хооронд харилцан итгэлцэл, сайн хөршийн болон найрсаг харилцааг бэхжүүлэх, улс төр, эдийн засаг шинжлэх ухаан технологи, соёл боловсрол, эрчим хүч, тээвэрлэлт, хүрээлэн буй орчныг хамгаалах болон бусад салбарт үр ашигтай хамтын ажиллагааг эрчимжүүлэх, бүс нутгийн энх тайван, аюулгүй, тогтвортой байдлыг хамтран баталгаажуулах, ардчилал, хууль зүй, шударга ёсонд нийцэх олон улсын харилцааны шинэ дэг журмыг бий болгох явдал" гэв.
- 2004 оны 1-р сард Бээжин хотноо ШХАБ-ын Нарийн бичгийн даргын газрыг нээснээр бүтэц зохион байгуулалтын хувьд энэ байгууллага цаашид баттай төлөвших үйл явцад зохих нөлөө үзүүлэх нөхцөл бүрдлээ гэж үзэж болох талтай.
- Терроризмын эсрэг тэмцэх бүс нутгийн бүтцийг Киргизстаны нийслэл Бишкек хотноо байгуулна хэмээн баримт бичгүүддээ тусгасан ч 2003 онд Москвад болсон дээд хэмжээний уулзалтаар 2004 оны 1/1-нээс Узбекстаны нийслэл Ташкентад албан ёсоор нээхээр болсон. Энэ нь Узбекстан улс АНУ-тай цэргийн салбарт нягт хамтран ажиллаж буй байдлыг сааруулж, хүчний тэнцвэрийг хадгалах гэсэн Орос, Хятадын сонирхолтой холбоотой. Мөн Хятад, Киргизстан хоёр терроризмын эсрэг цэргийн хамтарсан сургууль болсны дараа ШХАБ-ын 5 гишүүн Орос, Хятад, Казахстан, Киргизстан, Тажикстан терроризмын эсрэг хамтарсан цэргийн сургуулийг 2002 оны 8-р сард хийв. Ийнхүү терроризмын эсрэг тэмцэх байнгын ажиллагаатай бүтцийг үүсгэн байгуулсан, энэ чиглэлийн зарим эхлэлийг хийж буй нь бүс нутагтаа терроризмын аюулыг тодорхой хэмжээнд бууруулах боломжийг өгөх болов уу.

Сөрөг зүйл:

- Төлөвшилт нь хаашаа эргэх нь одоохондоо хараахан мэдэгдэхгүй байгаа болохоор энэ байгууллагын ирээдүй бүс нутагт аюулгүй байдлын хувьд ямархуу үүрэг гүйцэтгэх зэрэг нь тодорхойгүй, бүрхэг хэвээр байна. ШХАБ-аас явуулж буй үйл ажиллагаа сул, зөвхөн төр, засгийн тэргүүн, гадаад хэргийн сайд нарын хэмжээнд уулзалт хийх төдийхнөөр

хязгаарлагдмал хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, бие даан үйл ажиллагаа явуулахад туршлага бага байгаа зэрэг нь байгууллагын ирээдүйг бүрхэг болгож байна.

- Нэгдмэл санаа зорилго байхгүй байдал. 2001 оны 9-р сарын 11-ний үйл явдлын дараагаар өөрийн нутаг дэвсгэрийг терроризмын эсрэг тэмцэлд ашиглуулах тал дээр гишүүн улсууд нэгдмэл санаа зорилготой байж чадаагүй. Оросын хувьд гадны цэргийн оролцоог амин чухал эрх ашгийн бүсийн дотор оруулахыг хүсэхгүй байхад Төв Азийн улсууд нутаг дэвсгэртээ АНУ-ын цэргийг оруулж өнөөдөр ч гэсэн хамтран ажиллаж байна. Ялангуяа цэргийн салбарт Узбекистан улс АНУ-тай ойртон түншлэх болов. Узбекистаны ерөнхийлөгч И.Каримов 2002 оны 3-р сард Вашигтонд хийсэн айлчлалынхаа явцад "АНУ-ын цэрэг Узбекстаны нутаг дэвсгэрт өөрийн ашиг сонирхлын үүднээс хугацаа харгалзахгүйгээр байрлаж болно" гэж мэдэгдсэний хариуд АНУ нь стратегийн түншлэлийн тунхаглал байгуулж, "Узбекстанд учрах гадны аливаа аюул заналыг тогтоон барихад анхаарал хандуулах амлалт" авсан байдлаас үүнийг тодорхой харж болох юм.
- ШХАБ-ыг өргөжүүлэх үйл явц удаашралтай байгаа байдал. ШХАБ-ын гишүүнээр элсэх хүсэлтээ Энэтхэг, Пакистан улсууд тавьсан ч ШХАБ-ын гишүүн орнууд санал зөрөлдсөний улмаас өнөөдрийг хүртэл шийдэж чадаагүй. АНУ-ын зүгээс ШХАБ-ыг дэмжсэн юмуу сөргөсөн ямар нэг мэдэгдэл, үйлдэл хийхгүй, ямар ч атугай өнгөн дээрээ үл анзаарагчийн дур эсгэж байгаа нь анхаарал татаж байна.

Энэ бүгдээс харахад цаашид ШХАБ-ын оршин тогтнох үндэс суурь болсон нэгдмэл байдал, санхүүгийн эх үүсвэр муутай байгаа нь олон талын хамтын ажиллагааны төлөвшилтөнд нь дөнгө болж болох юм. Терроризмын өсөлт, их гүрнүүдийн сонирхол Төв Азид байгаа цагт аюулгүй байдлын олон талын хамтын ажиллагааг хүссэн ч хүсээгүй ч идэвхжүүлэхээс өөр замгүй. Тиймээс АСЕАН-ны бүсийн чуулга АРФ шиг байгууллагыг ШХАБ-ын дэргэд байгуулан аюулгүй байдлын асуудлыг авч хэлэлцдэг болгоод түүндээ АНУ, Монгол болон бүс нутгийн бусад улс орныг яриа хэлэлцээний түнш аль эсвэл зөвлөлдөх түнш болгон хамтарч ажиллаж гэмээ нь ирээдүйд энэ байгууллага аюулгүй байдлын хүчтэй олон талт механизм болж төлөвших боломжтой юм.

Ч.Баярманлай (Гадаад Хэргийн Яам): Өнөөдөр бид эрдэмтдээсээ практикийн юм сонсоё гэж ирсэн. Энэ асуудал бол өнөөгийн Монгол Улсын гадаад бодлогод чухал асуудал мөн. Бид Төв Ази гэж юу вэ хэмээн маргах нь өнөөдрийн хувьд тийм ч чухал асуудал биш. Улс төр, газар зүйн байршил, эдийн засгийн тодорхойлолтууд байна. Гэхдээ Төв Азийн орон гээд тодорхойлчихсон орнуудаа л үүндээ оруулж яримаар байна. Хаа холын ямар нэгэн юмыг нуур уу тэнгис үү гэж маргаад байх асуудал ерөөсөө бидэнд алга. Каспийн тэнгисийн нефтийг хэн яаж хуваах нь бидний санаа зовж оролцоод байх асуудал ч биш. Зүгээр тэр нь зүйтэй, энэ нь зүйтэй гэж судалж л байгаа юм. ЗХУ-ын задралын дараа бий болсон, үндсэндээ Дундад Азийн таван орныг Төв Азийн орнууд гэж хэлээд байгаа юм. Яагаад гэвэл Төв Азийн гэгдэж буй дээрхи 5 орон дээр үеэс хавчигдмал, барууны орнуудын ашиг сонирхлын бүс байсан. Англий колоничлолд ч орж байсан, мөн Афганистаны асуудал байна. Ингээд сөргөлдөөний талбар болж буй учраас өнөөдөр анхаарлын төвд болоод байгаа юм. Газар зүйн хувьд манай Монголыг хассан гэх хэрэггүй, Монгол нутагтаа байдгаараа л байна. ЗХУ задарснаар Төв Азид геополитикийн ашиг сонирхол ихэссэн. АНУ-ын, Лалын шашинт орнуудын, БНХАУ-ын ч геополитикийн ашиг сонирхол яахын аргагүй орж ирсэн. Энэ нь хаант засгийн үеэс л ОХУ-ын ашиг сонирхлын бүс байсан. Үүнийгээ алдах гээд байгаа учир сэргээх гэж тодорхой тодорхой алхмуудыг хийж байна. Энэ дээр ШХАБ-с гадна Евразийн эдийн засгийн хамтын нийгэмлэг, Хамтын аюулгүй байдлын гэрээний байгуулга маш эрчимтэй ажиллаж байна. Энэ нь ОХУ-ын геополитикийн их тодорхой илрэл юм. Энэ талаар бид тодорхой ярилцах ёстой гэж үзэж байна. Хэсэг эрдэмтдийн зүгээр нэг маргах сэдэв биш баймаар юм. Өнөөдөр бид 2.5 сая хүн амтай, яг үнэндээ дундаас доош хотын хэмжээний л хүн ам шүү дээ. Бид нэлээд эрт үед тусгаар тогтносон, дэлхийн олон улсын байгууллагын гишүүн учир дэлхийн хийгээд бүс нутгийн олон улсын болоод бүс нутгийн аюулгүй байдлын талаар ярих нь зөв гэхдээ зарим асуудлаар хэр хэмжээндээ тохируулж ярьж байх нь зүйтэй байх. Энэ бүс нутгийн улс орнууд өнөөдөр их гүрнүүдийн ашиг сонирхлын төвд байгаа нь үнэн гэхдээ ойрын 5-10 жилд энэ бүс нутагт эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс гадаадын томоохон хөрөнгө оруулалт орж ирэх нь юу л бол. Бид ойр зэргэлдээ буюу хөрш оршдгийн хувьд энэ бүс нутгийн улс орнуудад явагдаж байгаа үйл явцыг ажиглан судлаж байх шаардлагатай.

М.Батчимэг(ССХ-ийн ахлах судлаач): ШХАБ-ын төлөвшил эрчимтэй явагдаж байгаа ч одоогоор Төв Азийн байдлыг тогтворжуулахад тодорхой бөгөөд дорвитой хувь нэмэр оруулж, байр суууриа бэхжүүлсэн гэж үзэхэд эрт байна. Бүр Шанхайн Тавын үеэс л гишүүн орнуудын хүрээнд хилийн бүс дэх цэрэг зэвсэглэлээ харилцан хорогдуулах, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх зорилт дэвшүүлж ирсэн ч энэ хүрээнд чухам ямар ахиц гарсан талаарх мэдээлэл олон улсын түвшинд төдийлөн тодорхойгүй хэвээр байгааг судлаачид тэмдэглэдэг.

2001 оны 9-р сарын 11-ний үйл явдлын нөлөөгөөр АНУ-ын Төв Ази дахь нөлөө огцом өссөн нь дөнгөж байгуулагдаад байсан ШХАБ-ын өмнө шинэ сорилт авч ирсэн юм. Түүнчлэн ШХАБ-ын гишүүн орнууд болж буй үйл явдлуудын талаар нэгдмэл байр суууриа илэрхийлэх нь бүү хэл тус тусын ашиг сонирхлыг чухалчилсан байдлаар хандаж байсан нь хүмүүст ШХАБ-ын ирээдүйн талаар ихээхэн эргэлзээ төрүүлсэн. Зарим хүмүүс БНХАУ-ын зүгээс Төв Азид нөлөөгөө бэхжүүлэхийн төлөө гаргасан олон жилийн хүчин чармайлт талаар өнгөрч байна хэмээн үзэж ч байв.

Гэвч Хятад Оросын зүгээс ШХАБ-ыг үргэлжлүүлэн бэхжүүлэх талаар ихээхэн хүчин чармайлт тавьсаар байгааг дээр дурдсан билээ. Тус хоёр улс ШХАБ-ын гишүүнчлэлийг өргөжүүлэхэд ихээхэн анхаарал тавьж байгаа нь үүний нэг илрэл. Энэтхэг, Пакистан 2 улс элсэх сонирхлоо илэрхийлсэн талаар Орос, Хятадын хэвлэлүүд мэдээлсэн. Мөн Монгол Улсыг элсүүлэх сонирхлоо Орос, Хятадын зүгээс тодорхой илэрхийлж байгааг бид мэдэж байгаа.

Харин манайд ШХАБ-д элсэх асуудлаар дотооддоо нэгдмэл ойлголцолд хүрээгүй байна. Энэ асуудлаар зарим эрдэмтэд, улс төрчдийн хэвлэл мэдээллээр илэрхийлж байгаа байр суурийг анзаарахад ерөнхийдөө байдлыг ажиж хүлээзнэх нь зүйтэй гэсэн үзэл бодол давамгайлж байна. Төрийн засгийн зүгээс ч энэ асуудлаар нийтэд албан ёсны байр суууриа илэрхийлээгүй байгаа. Манай Гадаад Хэргийн сайд энэ оны эхээр ШХАБ-ын Гадаад Хэргийн сайд нарын уулзалтад анх удаа урилгаар оролцсон.

Миний бодлоор Монгол Улс ШХАБ элсэх эсэх тухай асуудлыг авч хэлэлцэхдээ дээр өгүүлсэн нөхцөл байдлуудыг харгалзан үзэхийн зэрэгцээ доорх асуудлуудад түлхүү анхаарал хандуулах шаардлагатай болов уу гэж үзэж байна. Үүнд:

1. Тус байгууллага цаашид АНУ тэргүүтэй өрнөдийн орнуудын эсрэг хүчний тэнцвэр хадгалах далд зорилго бүхий цэрэг улс

төрийн эвсэл шинжтэй байгууллага болон төлөвших үү эсвэл хамтын аюулгүй байдлын үзэл баримтлал, бүс нутаг, олон улсын хамтын ажиллагааны зарчмыг удирдлага болгосон нээлттэй байгууллага болон хөгжих үү гэдгийг ажиглах хэрэгтэй болов уу. Ер нь Төв Ази урт хугацааны туршид их гүрнүүдийн ашиг сонирхлыг хөндсөн бүс нутаг байх нь тодорхой байгаа бөгөөд их гүрнүүд энд өрсөлдөх үү эсвэл бие биеийнхээ ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрч хамтран ажиллах уу гэдэг нь л хамгийн гол зангилаа асуудал байх. Хэрэв ШХАБ эвслийн шинжтэй бодлого, үйл ажиллагаа явуулах нь тодорхой болох аваас тус байгууллагад элсэх нь "цэргийн аливаа эвсэл, бүлэглэлд үл нэгдэх", "гуравдагч хөрш"-үүдтэй ойр дотно харилцаатай байх Монгол Улсын гадаад бодлогод харшлах болно. Иймээс цаашид ШХАБ гадаад хамтын ажиллагаанд хэрхэн хандаж байна вэ, тухайлбал АНУ, Европын Холбоо болон бүс нутгийн хамтын ажиллагааны бусад байгууллагуудтай хэрхэн харьцаж байна вэ гэдэгт түлхүү анхаарах нь зүйтэй юм. АНУ-аас БНХАУ-д суугаа элчин сайд Кларк АНУ-ын зүгээс ШХАБ-д ажиглагчаар оролцох асуудлыг хоёр удаа хөндөж байсан боловч Хятадын талаар аливаа хариу байр суурь илэрхийлсэн зүйл олж сонсоогүй байгаа талаараа саяхан Бээжинд ЗХА-ийн судлаачидтай хийсэн уулзалтын үеэр онцлон тэмдэглэж байсан.

2. Тус байгууллагын хүрээнд эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимтэй хөгжүүлэх зорилт тавигдаж, гишүүн орнууд нь сүүлийн үед энэ асуудлуудаар эрчимтэй зөвлөлдөж байгаа. Гэвч эдийн засгийн хамтын ажиллагааны асуудлууд одоогоор зөвхөн цаасан дээр байгаа бөгөөд, тэдгээр зорилтыг ажил хэрэг болгоход гишүүн орнуудын зүгээс багагүй хүчин чармайлт, харилцан ойлголцол, хамтын ажиллагаа шаардагдах болно. Иймээс үүнд үргэжлүүлэн анхаарал тавих шаардлагатай болов уу. Хэрэв эдийн засгийн хамтын ажиллагаа, ялангуяа байгууллагын гишүүн орнуудын хооронд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулагдах, зам тээврийн бодлогын зохицуулалт зэрэг нь бодитой хэрэгжих төлөв бүрдэх аваас эдгээр хамтын ажиллагаанд оролцох нь бүс нутгийн эдийн засгийн интеграцаас хоцорч яваа Монгол Улсын хувьд

хөгжилд таатай боломжуудыг нээж өгнө. Саяхан БНХАУ-аас Монгол улсад суугаа элчин сайд ШХАБ-ын гишүүн орнуудын хооронд авто замаар чөлөөтэй зорчдог болох тухай асуудал хэлэлцэгдэж байгаа талаар ярьж байсан. Энэ асуудал бодитой хэрэгжвэл далайд гарцгүй манай орны хувьд олон улсын зам харилцааны чиглэлд мөн нааштай боломж нээгдэх талтай.

3. ШХАБ-ны байгууллагын нэг гол зорилт нь лалын хэт даврагсад, үндэстний салан тусгаарлагчидтай хамтран тэмцэл хийх явдал мөн. Монгол Улс хэдийгээр терроризмын эсрэг олон улсын эвсэлд нэгдэж, энэ чиглэлээрх олон улсын хүчин чармайлтад хувь нэмрээ оруулахыг эрмэлзэж байдаг ч, өөрийн ашиг сонирхлыг шууд хөндөөгүй үндэстний, болон шашны асуудалд хөндлөнгөөс хутгалдан оролцох нь аюулын шинэ эх үүсвэрийг өөртөө буй болгож болзошгүй гэсэн болгоомжлол дотоодын эрдэмтэд судлаачдын дунд нэлээд байдаг. Сүүлийн үед Ирактболж байгаа үйл явдлууд ийм сургамжийг бидэнд өгч байна. Иракийн хувьд Монгол Улс АНУ-ын байр суурийг дэмжсэнээр хариуд нь тодорхой хэмжээний улс төрийн дэмжлэг, эдийн засгийн тусламж авах, их гүрнүүдийн хүчний тэнцвэр дээр зөв зогссоноор гадаад харилцаандаа зарим ахиц гаргах боломж гарсан. Харин ШХАБ энэ тал дээр бидэнд юу өгөх вэ гэдгийг сайтар бодох ёстой болов уу. Тэр тусмаа Төв Ази бол алс холын Ирак бус, манай зэргэлдээ бүс нутаг.
4. ШХАБ бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүлээн зөвшөөрөгдсөн олон талын байгууллага болох, цаашид Ази Номхон Далайн бүс нутгийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны нэгэн бүрэлдэхүүн болж төлөвших хандлага байгаа эсэхэд мөн анхаарлаа хандуулж судлах хэрэгтэй байх.

Дээр ярьсан зүйлээс дүгнэлт хийхэд, Төв Азийн бүс нутгийн өнөөгийн байдал ч, ШХАБ-ны хөгжлийн чиг хандлага ч бүрэн гүйцэд төлөвшөөгүй байгаа өнөөгийн нөхцөлд манай улсын хувьд уг байгууллагад яаран нэгдэх бодит шаардлага үгүй байгаа гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл Монгол Улс өнөөгийн түвшинд ШХАБ-д нэгдсэнээр ашиг сонирхлоо хэрхэн урагшлуулж болох вэ гэдэг асуудал төдийлөн тодорхой бус, нөгөө талаас сөрөг үр дагавар гарч болзошгүй байдал ажиглагдаж байгаа нь үйл явдлын өрнөлийг үргэлжлүүлэн ажиглаж, хүлээзнэсэн байр суурь баримтлах нь зүйтэй болов уу гэсэн сэтгэгдлийг төрүүлж байна. Гэхдээ уг байгууллагын чиг хандлагыг, явуулж байгаа үйл ажиллагааг

ойроос ажиглаж, гишүүн орнуудын байр суурийг ойлгож байх нь цаашид энэ чиглэлийн бодлогыг оновчтой тодорхойлоход тустай. Иймд нэгэнт хоёр хөрш орны зүгээс Монголыг ШХАБ-д элсүүлэх сонирхлоо нэлээд идэвхитэй илэрхийлж байгаа нөхцөлд тус байгууллагад ажиглагч, эсвэл зочны статусаар элсэх асуудлыг судлан үзэх нь зүйтэй болов уу.

Л.Алтанзаяа (БИС-ийн Түүх нийгмийн ухааны сургуулийн захирал, Ph.D): Төв Ази судлалын асуудлаар судалгааны шинэ үр дүнтэй танилцах завшаан олгосонд Олон Улс Судлалын Хүрээлэнд талархлаа илэрхийлье. Сая эрдэмтэн, багш нар, Гадаад Хэргийн Яамны холбогдох албаны хүмүүсийн илтгэснийг анхааран сонслоо. Энэ сэдэвтэй холбогдуулж хэлэхэд манай сургуульд орчин үеийн дорно, өрнийн улсуудын харилцаа, түүний дотор Төв Азийн түүх, өнөөгийн тулгамдсан асуудлыг оюутнуудад сонгон мэргэших хичээлээр зааж байна. Бидний ойлгож байгаагаар, орчин үеийн олон улсын харилцааны өөрчлөлттэй холбоотойгоор Төв Азийн бүс нутаг, Зүүн Хойд Азийн улсуудын хамтын ажилгааны тухай асуудалд манай судлаачдын анхаарал чиглэж байгаа болов уу. Төв Азийн орнуудын эдийн засгийн харилцааны судлалд Европын Холбоо, БНХАУ, АНУ, ОХУ-ын байр суурийг тодорхойлох нь чухал юм. Европ болон Зүүн Азийг холбосон зам тээврийн асуудал гарч ирж байна. Энэхүү Европоос Кавказ, Төв Азиар дамжин Зүүн Азийн орнуудал хүрэх зам тээврийн харилцаанд Монгол Улс хэрхэн хамрагдаж байгаа талаарх нухацтай судалгааны дүнг нийтэд танилцуулмаар санагдана. Нэг талаар Оросын Транссибирийн төмөр зам сүлжээний өнөөгийн байдал, нөгөө талаар Төв Азийг дамнасан зам тээврийн харилцааны асуудлаар АНУ-ын бодлого ямар байгааг судлууштай юм. Европын улс орнуудтай харилцахад Хятад нь Төв Азийн бүс нутагт зам тээврийн шинэ суваг бий болгох санаачилга гаргасан. Жишээ нь, Оросын судлаачдын тэмдэглэснээр, Хятад-Казахстаны хилээр дамжин тээвэрлэх худалдаан дахь контейнерийн тоо хэмжээ 1996-2000 онд наад зах нь 5 дахин өссөн байдаг. Тухайн асуудалд Төв Ази дахь Европ, АНУ-ын өрсөлдөөнийг ч харгалзан үзүүштэй. Цаашид олон улсын зам тээврийн шинэ сүлжээнд манай улс хэрхэн холбогдох боломжтой байна вэ? Энэ талаар эрдэмтэн судлаачид та бүхнээс тодотгож асуухыг хүсч байна.

П.Энхбаяр (Гадаад Хэргийн Яам): Манай эрдэмтэд, судлаачид Төв Азийн асуудлыг сонирхон судалж байдаг. Төв Ази нь

өнө эртнээс манай улстай холбоотой байсаар ирсэн. Өнөөгийн Төв Азийн орнууд олон талын оролцоотой хамтын ажиллагааны хэд хэдэн байгууллагад нэгдээд байгаа. Үүнд: Төв Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, Евразийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, ТУХН-ийн хүрээнд Хамтын аюулгүй байдлын байгууллага, түүнчлэн ОХУ, БНХАУ-ын хамт ШХАБ-д нэгдээд байгаа. Харин эдгээр байгууллагад Туркменистан нэгдээгүй ажээ. Төв Азийн орнуудаас Казахстан, Киргиз Улс ОХУ, Украинтай хамтран эдийн засгийн нэгдсэн орон зай байгуулах тухай Гэрээ байгуулж, эдгээр орнууд уг Гэрээг тус тусын Парламентаар батламжлаад байна. Казахстаны талын санаачилгаар байгуулсан олон улсын байгууллага - Азид итгэлцлийг бэхжүүлэх, хамтран ажиллах асуудлаарх Зөвлөлгөөнд Төв Азийн орнууд нэгдээд байна. Энэ Зөвлөлгөөнд Монгол Улс гишүүнээр нэгдэж, тус Зөвлөлгөөний гишүүн орнуудын 2002 онд Алма-Атыд болсон дээд хэмжээний уулзалтанд манай улсын Ерөнхийлөгч оролцсон юм.

Төв Азийн геополитик, геостратегийн орчин 2001 оны 9-р сарын 11-нээс хойш өөрчлөгдөв. Төв Азийн бүс нутаг нь цэрэг, улс төрийн төдийгүй эрчим хүчний нөөц эх үүсвэрээр их гүрнүүдийн эдийн засгийн сонирхлын нөлөө бүхий бүс нутаг юм. Өмнө нь тус бүс нутаг хуучин ЗХУ, одоогийн ОХУ-ын нөлөөнд байв. 2001 оны 9-р сарын 11-ний халдлагаас хойш олон улсын терроризмын эсрэг дэлхийн нийт нэгдэн тэмцэх шаардлагатай болж, үүнээс өмнө баримталж байсан дэлхийн дайны асуудлаарх ойлголт үндсээрээ өөрчлөгдөв. Энэ үйл явдлаас хойш олон улсын терроризм ганц нэг улсыг бус дэлхийн олон нийтийг түгшээх болсон. Төв Азийн орнууд нь Афганистантай хамгийн дөт замаар хил нэвтрэх боломжтой газар зүйн байрлалтай. Иймээс ч Төв Азийн орнууд АНУ-ын цэргийн хүчнийг нутаг дэвсгэр дээрээ байрлуулах болов. ОХУ гадаад дахь анхныхаа цэргийн баазыг Киргизд байрлуулав. Судлаачид манай улсыг Төв Азийн нутаг гэж тооцох нь олонтой. Европ, АНУ-ын судлаачид Монгол Улс нь Төв Ази дахь ардчиллын үлгэр дууриал хэмээн үзсээр буй. Монгол Улс Төв Азийн бүх улсуудтай дипломат харилцаатай. 1992 онд Төв Азийн улсуудтай дипломат харилцаа тогтоосноос хойш эдүгээ 10 гаруй жил болж байна. Манай улс Төв Азийн орон тус бүртэй харилцаж, хоёр ба олон талын хүрээнд хамтран ажиллаж байна. Казахстан, Киргиз улстай дээд, өндөр хэмжээнд харилцан айлчлал солилцож, Засгийн газар хоорондын комиссын хуралдааныг зохион байгуулж байгаа. Бусад улсуудтай нь элчин сайд нараа харилцан хавсран суулгаж, олон улсын арга хэмжээний үеэр

манай ерөнхийлөгч, гадаад хэргийн сайд нарын түвшинд хоёр талын болон олон улсын харилцааны асуудлаар санал солилцож байгаа. Алма-Атыд ажиллаж буй манай элчин сайдын яам Киргиз, Тажикистанд хавсран сууж байна. Мөн Туркэд суугаа элчин сайд Узбекстан, Туркменистанд хавсран сууж байгаа. Монгол-Казахстан, Монгол-Киргизийн Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны комиссын хуралдаанууд энэ онд Алма-Аты, Бишкект болсон. Төв Азийн орнуудтай хоёр талаасаа харилцаагаа хөгжүүлэх сонирхол их байдаг боловч аль аль талдаа эдийн засаг, хөрөнгө оруулалтын бололцоо бага буй. Монгол Улсын хувьд Казахстанаас нийлүүлэх нефтийн хэмжээг нэмэгдүүлэх, Туркменистан, Узбекистан зэрэг орноос нефть нийлүүлэх боломжийг судлах хэрэгтэй буй. Казахстанаас оруулж буй нефтийн хэмжээ 2003 онд өмнөх оныхоос бараг 5 дахин нэмэгдсэн. Казахстан нь Дэлхийн худалдааны байгууллагад элсэхээр бэлтгэж байгаа. Казахстаныг ДХБ-д элсүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монгол Улс гишүүнээр ажилладаг. Киргизийн хувьд аялал жуулчлалын чиглэлээр хамтран ажиллах бололцоотой. Төв Азийн аль ч оронтой аялал жуулчлал, агаарын харилцааны чиглэлээр хамтран ажиллах өргөн боломж бий. Төв Азийн орнууд Зүүн Хойд Ази, Япон болон бусад орнуудтай Монголоор дамжиж агаарын замаар харилцах сонирхолтой байдаг. Энэ чиглэлд одоогоор тогтсон олон улсын томоохон нислэг бий болооогүй байна. Эдгээр орнуудтай аль аль талаасаа харилцааны эрх зүйн үндсээ бэхжүүлэхийг эрмэлзэж байгаа. Төв Азийн орнууд Монгол Улстай өнө эртний холбоотой. Манай улсын нутаг дэвсгэр дээрх түүхийн дурсгалт зүйлс Төв Азийн орнуудын өндөр хүндэтгэл хүлээдэг. Түрэг гаралтай улсууд манай нутаг дэвсгэр дээрх хүн чулуу, Күльтигэн, Таньюгукийн хөшөө зэргийг хүндэтгэж, ихэд сонирхдог учир жуулчлалын урсгалыг бий болгох бололцоотой. Эндээс соёл иргэншлийн ихээхэн таашаал авдаг. Түрэг гаралтай улсаас ирэгсэд манай улс дахь өөрийн улсынхаа түүхэнд холбогдох эртний хөшөө дурсгалтайгаа танилцаад Меккад очсоноос ялгаагүй боллоо хэмээн үзэх нь бий. Манай эриний 800-гаад оны үед эртний хиргисүүд Монголд амьдарч байжээ. Тэдний оршин байсан газар нутгийг өнөөгийн Киргиз Улс ихэд хүндэтгэн үздэг. Хиргисүүд эртний Уйгурыг бут цохиж ноёрхолоо тогтоож байгаад нүүн шилжжээ. Хяргас нуурыг Киргиз нуур хэмээн нэрлэдэг. Хяргас нуурын орчинг өөрсдийн өнө эртний эх нутаг гэж хүндэтгэн үздэг. 2002 онд Киргизийн Ерөнхийлөгч А.Акаев Монголд айлчлахдаа Хяргас нуурт зочилсон юм. Хяргас нуурын эрэг орчимд киргизүүд олон улсын

хэмжээний аялал жуулчлалын бааз байгуулах талаар хамтран ажиллахад бэлэн гэдгээ нотолж байгаа. Энэ чиглэлээр хоёр талын аялал жуулчлалын компаниуд хамтран ажиллах бололцоотой. Алтай Таван Богд ууланд олон улсын адал явдалт, шинжлэх ухаан, судалгааны чиглэлийн авиралт хийх санал казахстаны талаас тавиад байгаа. Үүнийг Төв Азийн орнуудтай ойрын үед хэрэгжүүлэх бололцоотой. Эдгээр орнуудтай хамтарч түүхээ судлах, түүхэн үйл явдлуудад үнэн бодитой дүгнэлт өгч дараагийн үедээ дэлгэж тавих нь манай эрдэмтдийн хамтын ажиллагааны нэг зорилт байх учиртай. Төв Азийн орнууд шашны хувьд лалын шашинтай бусад орнуудтай харьцуулахад соёл иргэншлийн илүү өндөр түвшинд хүрсэн гэж үздэг. Учир нь дан ганц шашнаа шүтээд хөгжлийн хаагдмал байдалд ороогүй, шашнаа төрөөс тусгаарлаж, хэл соёлоо хадгалж Европ руу хандсан хөгжлийн чиг хандлагыг сонгосон. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд эдгээр орнуудад Ерөнхийлөгч, Парламентын засаглалыг бүх ард түмний сонгуулиар байгуулах тогтолцоонд шилжсэн боловч аль ч оронд нь улсын ерөнхийлөгч нь солигдоогүй хүчтэй ерөнхийлөгчийн засаглал тогтсон хэвээр байгаа.

ШХАБ-ыг манай судлаачид сонирхон судалж байна. Судлаачдын байр сууриас үзэхэд тус байгууллага цэрэг улс төрийн буюу эдийн засаг, шинжлэх ухаан техник, хүмүүнлэгийн зэрэг аль чиглэлийг гол болгож хөгжих нь вэ гэдгийг анхааралтай ажиглаж байгаа нь харагдаж байна. 2004 оны 1 дүгээр сард Бээжинд болсон ШХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалтанд манай улсын Гадаад хэргийн сайд Л. Эрдэнэчулуун зочноор оролцсон. Тус байгууллагын гишүүн орнуудын сайд нартай уулзаж, хоёр ба олон талын хүрээний асуудлаар санал бодлоо солилцсон. Хэрэв тус байгууллага эдийн засгийн хамтын ажиллагааг тэргүүн ээлжинд тавьж, бүс нутгийн интеграцчлал, худалдааг либералчилах зэрэг чиглэлээр хөгжих тохиолдолд манай улс тус байгууллагатай хамтран ажиллах чиглэлийг сонгох нь зүйтэй болов уу. Манай улсын хувьд тус байгууллагын гишүүн улс орон бүртэй хамтран ажиллаж, тус байгууллагын үйл ажиллагааг хүндэтгэн үзэж байгаа.

Манай улс зам харилцааны хувьд Төв Азийн бүс нутагт холбогдох боломжтой болж байгаа. Казахстантай Оросын нутгаар дамжин холбогдож байгаа. Энэ замыг хатуу хучилттай болгож дуусгах ажил Казахстаны талаас хийгдэж дуусч байна. Цаашдаа манай "Мянганы зам" Төв Азийг Зүүн Хойд Азитай холбох гол зам болно. Энэ замын

барилга байгууламжид бид Төв Азийн орнуудыг оролцуулан олон улсын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой.

А. Түвшинтөгс (ССХ-ийн дэд захирал, PhD): Оросын талаас интернетээр цацаж буй мэдээлэлд ирэх 6-р сард болох ШХАБ-н дээд хэмжээний уулзалтанд Афганистан, Монголын ерөнхийлөгч нар оролцоно гэсэн байх юм. Манай талаас тийм юм байгаа юм уу?

Ц.Доржсүрэн (Гадаад Хэргийн Яам): Тийм шийдвэр гараагүй. Манай тал Бээжинд болсон сайд нарын хуралд урилгаар оролцсоны дараа хэвлэл, мэдээллийнхэнд тийм ойлголт төрсөн байж болох. Тийм бол энэ нь ташаа ойлголт. Ер нь манай улс ШХАБ-д гишүүнээр элсээгүй боловч энэ нь геополитик, газарзүйн үүднээс манай улсын эргэн тойронд явагдаж байгаа үйл явц учраас манай улс хэрхэн хандаж байна гэдгийг бусад улс орон сонирхож ажиглан харж байдаг байж болох юм.

Энд яригдаж байгаа зарим зүйлийн талаар товч дурдахад Төв Ази бол түүхэн утгаараа тодорхой газар зүйн бүс гэдэг нь маргаад байх зүйл биш болов уу. Гэхдээ геополитикийн голдирол, геостратегийн үүднээс Төв Азийн улс орнуудын статус чухам хэдийгээс улс төрийн шинж чанартай болсон бэ гэдэг асуулт байсаар байна. Нөгөө талаар хуучин ЗХУ задарснаар түүний нутаг дэвсгэр дээр олон улсын харилцааны, олон улсын анхаарлыг татсан, тодорхой улс гүрнүүдийн ашиг сонирхлын илэрхийлэл болсон бүсүүд гарч ирсэн гэдэг талаас нь авч үзвэл өнөөдрийн байдалд илүү ойр байх болов уу. ЗХУ задрахад хэд хэдэн, тухайлбал Балти, Төв Ази, Кавказын болон Европын орнуудын төв бий болж, нөлөө бүхий улс орнууд эдгээр төв бүрт өөр өөрийн сонирход тулгуурлсан өвөрмөц өнгө аястай бодлого явуулж ирсэн. Энд яригдаж байгаа Төв Азийн бүст улс орнууд орчин үеийн утгаараа хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан 5 улсыг ихэвчлэн авч үзэж байгаа нь харагддаг.

Нөгөө талаас интегарцчлалд оролцох асуудлын тухайд энд нэлээд яригдаж байна. Даяаршлын эринд аливаа улсын хөгжлийн асуудлыг аваад үзэхэд бүс нутгийн интеграцийн хүрээнээс гадуур төсөөлөхөд эргэлзээтэй болж байна. Манай улсын хувьд ч гэсэн дангаараа буюу хүчтэй төвд тулгуурласан интеграцчлал эсвэл бүс нутгийн ямар нэгэн хамтын ажиллагааны механизмд хамрагдахгүйгээр хөгжлийн төлвийг бүрэн утгаар нь төсөөлөхөд учир дутагдалтай болно байх. Манай улсын

хувьд өнөөгийн хөгжлийн замаар замнахдаа их төлөв хөрш орнуудтайгаа тогтоосон хоёр талын хамтын ажиллагаа, өндөр хөгжилтэй орнууд, хандивлагч хамтын нийгэмлэгтэй тогтоосон харилцаа, хамтын ажиллагаа, тэдний тусламж дэмжлэгт түшиглэх замаар нийгэм, эдийн засгийн салбарт манай орны өмнө тавигдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл манай бүс нутгийн бодит байдлаас хамаатай шалтгааны улмаас манай улс хамрагдсан бүс нутгийн үр ашигтай олон талт интегарцчлалгүй байна. Бид бүс нутгийн үүднээс авч үзвэл Зүүн Хойд Азид харьяалагдаж, өөрийн орны хөгжлийн ирээдүйг энэ бүс нутгийн цаашдын хөгжилтэй холбож үздэг. Харин Төв Ази, ЗХА-ийн бүс нутагт төлөвшин тогтсон интегарцчлалын механизм одоогоор үгүйлэгдсээр байна. Төв Азид төлөвших төлөвтэй хамтын ажилгааны дотоод механизм, ялангуяа ТУХН-ийн орнууд хоорондын хамтын ажиллагааны сүлжээ бий болсоор байна. Бид хөгжлийн талаар тавьж буй зорилт бол манай бүс нутагт явагдаж байгаа бүс нутгийн хамтын ажиллагаанд аль болох оролцох, ойроос ажиглаж байх сонирхлыг удирдлага болгодог. Тийнхүү ажиглаж байгаа нэг механизм нь ШХАБ мөн. ШХАБ-д бид ерөөс оролцоогүй явж ирсэн. Эрдэм шинжилгээний байгууллагын түвшинд ч тэр, бодлого хэрэгжүүлэгч институцийн хувьд ч алсын зайнаас ажиглаж ирсэн. Харин ойрын зайнаас ажиглаж, энэ байгууллагын үйл ажиллагааны чиглэл хандлагыг нарийн судалж ойлгох шаардлагатай байна. Манай Гадаад хэргийн сайд ШХАБ-ын гишүүн орнуудын сайд нарын уулзалтад урилгаар оролцсон явдлыг үүнтэй холбон авч үзүүштэй. Цаашид ШХАБ-тай ямар түвшинд хамтран ажиллах талаар бид судалгаа хийж, санал боловсруулах шатанд байна. Иймд гадаад бодлогын асуудлаар ийнхүү эрдэм шинжилгээний байгууллагууд санал солилцох уулзалт зохиож, судлаачид санал бодлоо чөлөөтэй солилцож байгаа нь чухал юм.

Н. Алтанцэцэг (МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн захирал, PhD): Олон улс судлалын хүрээлэнгээс Төв Азийн асуудлаар зохион байгуулсан дугуй ширээний ярилцлаганд олон газраас янз бүрийн мэргэжлийн хүмүүс ирж үзэл бодол, байр суурια илэрхийлж байгаа нь чухал зүйл. Өмнө үг хэлсэн хүмүүс миний хэлэх гэсэн санааг бараг гаргасан тул дахин нуршилгүй нэг санал дэвшүүлмээр байна. Манай сургууль, Стратегийн судалгааны хүрээлэн бусад газрууд ч иймэрхүү арга хэмжээг олон удаа дангаараа болон хамтран зохион байгуулдаг. Гэтэл үүнийг бодлого боловсруулдаг,

шийдвэр гаргадаг хүмүүс хэрхэн хүлээж авдаг, хүрдэг эсэх нь сайн мэдэгдэхгүй байна. Иймд ижил төстэй судалгаа хийдэг байгууллагууд, эрдэмтэн судлаачид, практикийн байгууллагуудтай хамтран ажиллах үр ашигтай механизмыг олох, бий болгох шаардлагатай байна. Энэ нь нэг талаасаа хөрөнгө хүчээ тулгамдсан асуудлуудад төвлөрүүлэх, нөгөө талаас бидний судалгаа, үзэл бодол, таамаглал зохих байгууллага, хүмүүст хүрч байх, бидний ажлын үр дүн тодорхой, бодитой болох нөхцөл бололцоог бий болгоно хэмээн бодож байна.

Д.Шүрхүү (ОУСХ, PhD): Өнөөдрийн дугуй ширээний ярилцлага хэлэлцсэн асуудал, хөндсөн сэдэв, оролцогчдын бүрэлдэхүүн зэрэг аль ч талаас нь авч үзсэн үнэхээр сонирхолтой, үр дүнтэй, цаашдын судалгаанд түлхэц болохуйц, судалгаа, сургалт практикийн байгууллагуудыг холбосон чухал уулзалт боллоо. Бид энэхүү уулзалт ярилцлагыг зохион байгуулахдаа өнөөгийн олон улсын харилцаанд чухал байр суурь эзэлж, их гүрнүүдийн анхаарлын төвд орж буй, мөн бидний баруун талд ойрхон буй хөрш Төв Азийн бүс нутгийн талаарх дотоод, гадаадын эрдэмтдийн судалгааны ажлын сүүлийн үеийн үр дүнг уншигчиддаа хүргэх, өөр хоорондоо мэдээлэл солилцох, тэр хэмжээгээрээ энэ талын судалгааг хөгжүүлэн, түлхэц өгөхийг гол зорилго болгосон билээ. Эл зорилгодоо ч хүрсэн хэмээн бодож байна.

Сүүлийн жилүүдэд дотоодод төдийгүй гадаад орнуудын зүгээс Монгол Улс, монголын эрдэмтэн судлаачид Төв Азийн асуудал, хөгжлийн хэтийн төлөв, түүний дотор Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын талаар ямар байр суурь үзэл бодолтой байгааг мэдэх гэсэн хүсэл сонирхол нэлээд мэдрэгдэх боллоо. Монгол Улсын зүгээс зарлан тунхаглаад буй олон талт, нээлттэй, идэвхитэй гадаад бодлогод Төв Азийн бүс ямар үүрэг холбогдолтой байхыг одооноос сайтар судлах бодит шаардлага ч байна. Мөн уригдан ирсэн их дээд сургуулийн багш нар ч Төв Азийн бүсийн талаарх мэдээлэл, судалгаа өгүүлэгдэж буйг ч дурдлаа. Цаашид бидэнд хийх, судлах, хамтран хийх ажил их байна. Манай сэтгүүлийн редакцийн урилгыг хүлээн авч, дугуй ширээний ярилцлагад идэвхитэй оролцож эрдэм судлалын бүтээл туурвилаас өргөн барьсан, чухал мэдээлэл, санал бодлоо хуваалцсанд та бүхэнд хүрээлэнгийн хамт олон, олон зуун уншигчдынхаа нэрийн өмнөөс дахин талархлаа илэрхийлье.